

Андерсены

үлгэрүүд



АНДЕРСЕНЫ ҮЛГЭРҮҮД

Сургуулийн бага, дунд насныханд зориулав.

Улаанбаатар хот
2007 он

АНДЕРСЕНЫ ҮЛГЭРҮҮД

Сургуулийн бага, дунд насныханд зориулав.

Орчуулсан Д.Цоодол

Зураач Н.Хүдэрчулуун
Хянан тохиолдуулагч О.Мөнхтуяа
Хянагч Ж.Гэрэлмаа
Хэвлэлийн эх бэлтгэсэн Д.Хишигдэлгэр



Хэвлэн нийтлэлийг Интерпресс ХХК

2007 он

Хэн нь хурдан бэ?

Амьтдын дунд шагнал олгох юм болов. Их бага хоёр янзын шагнал юм санжээ. Шагналыг нэгэн удаагийн хурдан гүйлтэд бус, бүр бүтэн жилийн турш хэн хурдан гүйсэнд нь олгох учиртай байлаа.

- Шүүгчид чиний найз нөхөд эсвэл хамаатан садан байвал шийдвэр нь ямагт зөв шударга байдаг. Тийм учраас ч би тэргүүн шагнал хүртлээ. Харин хоёрдугаар байрын шагналыг эмгэн хумст яагаад өгөв өө? Энэ нь надад буруу, бүр гомдолтой санагдаж байна гэж туулай хэллээ.

- Нэн эрхэм хүндэтгэлт шүүгчид уралдаанд оролцогчийн хичээл зүтгэл, ариун сайхан санааг харгалзан үзсэнийг бодолцон тэдний гаргасан дүнг би сайшааж байна. Хэдийгээр эмгэн хумс босгоо мөлхөн давах гэж хагас жилийг зарцуулсан нь үнэн боловч яарснаас болоод замд нь хавирга сүврэгээ хугалсан явдал хүртэл гарсан байна. Эмгэн хумс уралдахын тулд бүхий л бие, сэтгэл санаагаа зориулан тэмцэлдсэн нь үнэн. Тэгээд бас энэ бүхэн дээр өөрийн гэрийг нуруун дээрээ үүрч явсан билээ. Ийм их зүтгэл чармайлт гаргасан хэн боловч ямар ч урамшил шагналыг хүртэхэд болохгүй яах юм бэ, ийм учраас ч хоёрдугаар байр авчээ гэж шүүгчдийн ажиллагаанд гэрчээр оролцсон хашааны шон өгүүлэв.



- Та бүхэн над уруу анхаарлаа хандуулж болох сон болов уу. Миний бодоход энэ зуны хувьд надаас хурдан хэн ч байгаагүй гэж би зоригтой хэлнэ. Би зун хаа эс очив оо. Хаа сайгүй, бүх газар очсон билээ би гэж алтан хараацай өөрийн тухай ярилаа.

- Таны хамаг буруу наана чинь л байна даа. Та өвчтэй юм шиг л тэнээд байх юм. Энд хүйт эхлэнгүүт л өөрөө бусдын нутаг уруу арилаад өгдөг шүү. Та эх оронч бус байна. Ийм учраас таны тухайд яриад байх юм байхгүй ээ гэж хашааны шон хэллээ.

- Тэгвэл бүх жилийн турш намгийн дунд унтаж байвал надад анхаарлаа хандуулах болж байна уу гэж алтан хараацай сөргөн асуув.

- Тэгвэл чи үгүйдээ хагас жил ч болохноо нутагтаа байсан баримт намгийн оршин суугчдаас аваад ирээч. Үүний чинь дараа чамд анхаарлаа хандуулж болж л байна.

- Би тэргүүн шагналын амжилт гаргасан болохоос бус хоёрдугаарыг нь авахаар байгаагүй ээ. Би туулайг сайн мэднэ ээ. "Араас маань хэн нэгэн хаа ч яваа байж мэднэ" гэж айхдаа аймхайгаасаа л болоод тэр хурдалдаг. Харин би бол жинхэнэ амьдралынхаа төлөө алба ажилдаа санаа тавихдаа л яардаг юм. Байдал ийм байхад надад тэргүүн

шагнал олдохгүй гэж үү! Би өөрийгөө магтан хашгирах дургүй. Тийм явдлыг би жигшинэ гэснээ эмгэн хумс нулимж орхиод суув.

Шүүгчдийн нэг уулзварын багана саналаа хэлж эхлэв.

- Аливаа шагналд үгүй ядахдаа шударга хандах ёстой гэдгийг би та бүхэнд өөрийн зүгээс итгүүлэн хэлэхийг хүсч байна. Би ерөнхийдөө тоо хэмжээг удирдлага болгодог зарчимтай. Шагналд шалгаруулах ажиллагаанд би найм дахь удаагаа оролцож байгаа боловч энэ удаа л миний санал ёсоор боллоо. Урьд нь "С"- зэр эхэлсэн нэртэй амьтныг нэгдүгээрт, "С"- зэр төгссөн нэртэй амьтныг хоёрдугаарт шалгаруулж байв. Энэ удаа "Т"- гээр эхэлсэн нэртэй амьтныг




тэргүүн, "Э"- гээр эхэлсэн нэртэй бол хоёрдугаарт шалгаруулах болсон тул туулай, эмгэн хумс нар шалгарлаа. Дараагийн удаа шалгаруулахад тэргүүн шагналыг "И"- гээр эхэлсэнд "С"- зэр төгссөн нэртэнд удаах шагналыг олгох болно оо. Хамгийн гол нь бүх юманд энэ мэт журам чухал. Өөр ямар ч арга байхгүй ээ.

- Би шүүгчдийн багийн гишүүний хувьд биш зүгээр л өөрийнхөө тухай эрх биш ярьж хэлмээр байна. Ганцхан хурд бусад үзүүлэлтүүд тухайлбал, ачаа гэж юм бий шүү. Би үүн дээрээ тулгуурлан туулайны сэргэлэн ухаан буюу юмыг аргалдаг мөртлөө хэрхэн будлиулж, ойртон яваа аюулаас бултдаг зэргийг ярьж гэж бодохгүй байна. Гэвч яагаад ч тойрон өнгөрч болохгүй нэг зүйл байгаа нь царай зүсний тухай юм аа. Би туулайн энэ гоё чихийг харлаа л даа. Тэгэхэд хэн ч гэсэн хайр хүрмээр, чих нь миний багын чихтэй эгээ адилхан байлаа. Би бол туулайн төлөө саналаа өгсөн нь мэдээж.



- Шунни! Би олон үгээр уяхгүй ээ, хэдхэн үг хэлье. Би бол ямар ч туулайтай зэрэгцэх амьтан биш гэдэг нь надад тов тодорхой билээ. Тэр байтугай би саявтархан нэг туулайны хойд хөлийг хугалчихсан явдал бий. Би галт тэргээр явж байлаа л даа. Өмнө маань мань туулай явсан юм. Би хойд нэг хөл дээр нь очоод суучхав аа. Тэгтэл туулай хажуу тийшээ эргээд дэгдсэн чинь галт тэрэг хөл дээгүүр нь гараад явчихгүй юу. Туулай дороо л үлдлээ. Би ч яахав дээ нисээд л явчихсан. Тэгэхээр бид хоёрын хэн нь хурдан байна? Гэхдээ надад шагналын хэрэг байхгүй ээ гэж ялаа дүнгэнэн ярив.



- Миний бодлоор бол тэр өөрөө энэ талаар яриагүй. Ер нь түүний зан нь энэ тухайгаа хэзээ ч ярихгүй боловч хэрвээ ярьдаг сан бол үнэндээ нэг болоод хоёрдугаар байрын шагналыг авах гавьяатан зөвхөн нарны туяа л юм. Тэр нарнаас дэлхий хүртэлх хязгааргүй уудам орон зайг ганцхан хоромд туулан, бүх орчлон

хорвоог нойроос нь сэрээдэг билээ. Түүний зөөлхөн үнсэлтийн ачаар сарнай цэцэг бид улааран, анхилуун сайхнаар ханхалдаг юм аа. Харамсалтай нь эрхэм дээд шүүгчид үүнийг ер олж хараагүй байна. Хэрвээ би нарны туяа юм сан бол эдгээр шүүгчдийг нарны цохилтоор залхаах сан. Шүүгчид ухаан санаагаа алдаж, ядмаг дорой дээрээ улам ч бажгадах байлгүй. За за, амаа татъя. Ойд чимээ ч үгүй амар амгалан ямар сайхан гэж бодно. Бид үлгэр дуунд магтагдсан үүрийн шүүдрээр ундлан, тансаг сайхан үнэрээ түгээн, цэцэглэн дэлгэрэн байх ямар сайхныг хэлж барах уу. Гэрэлт нар та бидний бүгдийн төлөө оршин байдаг гэж хээрийн сарнай цэцэг ярив.



Энэ үес, удтал унтаж хоцроод, одооноос хөдөлж эхэлсэн чийгийн улаан өт:

- Тэргүүн шагналд юу өгсөн юм бэ, та минь гэсэн асуулт тавилаа.

- Манжин тарьсан хот уруу дуртай газраараа орох эрхээр шагнасан юм. Тэргүүн байрыг туулай авах учраас ухаантай, шагнал тодруулах хэсгийн нөлөө бүхий гишүүн туулайн хэрэгцээг бодож би энэ шагналыг санаачилсан юм гэж илжиг хариу өчжээ.

Тэр бас:

- Эмгэн хумсны хувьд замын хажуугийн чулуун дээр сууж наранд ээх, чулууныхаа хөвдийг идэх эрх олгосон болно. Түүнээс гадна эмгэн хумс манай шагналын хэсгийн гол гишүүнээр сонгогдсоныг мэдэгдье. Яагаад гэвэл манай хэсэгт нарийн мэргэжлийн гишүүд их хэрэгтэй байгаа юм. Энэ бүх сайхан эхлэлээс үүдэн шууд хэлэхэд манай шүүгчдийн хэсгээс маш олон сайхан ажил итгэн хүлээж болно гэж хэлэв.



Дэглий шувуудын тухай үлгэр

Нэгэн хотын захын жижигхэн байшингийн орой дээр дэглий шувуу үүрээ засчээ. Тэр одоохондоо улаан өнгөтэй болж амжаагүй байгаа бяцхан хар өнгийн хошуугаа үүрнээсээ үе үе цухалзуулан байх дөрвөн ангаахайтайгаа аж төрж байв. Үүрнээс холгүй байшингийн нуруун дээр эцэг дэглий харуулд гарч удаан зогсох учир нэг хөлөө гэдсэндээ хүртэл нугалж, өрөөсөн хөл дээрээ зогсдог байлаа.

Ингэж хаашаа ч үл хөдлөн зогсоо түүнийг модоор хийсэн шувуу ч юм уу гэж бодож болмоор харагдана. "Зүйтэй, хүндэтгэнэ гэдэг чинь л энэ юм даа! Эхнэрийн минь хувьд харуулын цэрэг нь л зогсож байна гэсэн үг. Түүний нөхөр гэж хэн мэддэг юм бэ. Яахав, намайг харуул нь ирээд зогсож байна гэж бодох нэг нь бодно л биз. Мөн ч их хүндэтгэж байна даа" гэж дэглий дотроо боддог байжээ.

Цаашдаа ч гэсэн бодсоор л, өрөөсөн хөл дээрээ зогссон хэвээрээ л байв. Энэ үес гудамжинд олон хүүхэд тоглож байжээ. Хүүхдүүд дэглий шувуудыг харан, тэдний хамгийн дүрсгүй нэг хөвүүн дэглий шувуудын тухай эртний нэгэн дууг үгийг нь өмнө, хойно нь оруулан дуулж эхэлсэнд, бусад нь бас түүнийг даган дуулж эхлэв.

Дэглий, дэглий цагаахан дэглий шувууд аа
Дэмий юунд өдөржингөө зогсоно вэ?



Өдөржингөө хүндэт харуулд та нар
Өрөөсөн хөл дээрээ зогсдогийн учир юу вэ?
Ангарай бяцхан үрсээ хамгаалах гэж тэр үү?
Аяндаа байтал бид тэднийг чинь авчих гэв үү?
Цөлмөж тэгвэл бид нэгийг нь шонгоос дүүжилнэ
Цөөрөмд хаяж нөгөөгий нь живүүлнэ
Ялгаагүй гурав дахийг нь юмаар хатгаж устгана
Ядмаг бүүр багыг нь түүдэг галд шиднэ
Яхав гэж та нараас бид асуухгүй...

- Хүүхдүүд юу гэж дуулахыг сонсооч! Биднийг өлгөнө, усанд живүүлнэ гэж байна гэж дэгдээхийнүүд шаагилдав.

- Тэднийг бүү анхаар. Сонсохгүй л байцгаа. Юу ч болохгүй гэж эх дэглий тэдэнд хэллээ.

Гэвч хүүхдүүдийн чимээ намдсангүй, дэглийнүүдийг дооглон дуулсан хэвээр. Харин тэдний дундаас Петер гэдэг хүү л бусад нөхөдтэйгөө санал нийлсэнгүй, "Аливаа амьтдыг тохуурхан доромжилно гэдэг бол нүгэлтэй явдал мөн" гэж хэлэх нь дуулджээ. Ээж нь аанай л дэгдээхийнүүдээ тайвшруулахыг хичээнэ.

- Тэднийг битгий анхаарцгаа. Хараач та нар, та нарын эцэг өрөөсөн хөл дээрээ хэчнээн тайван, найдвартай зогсож байна вэ.

- Үгүй, бид айгаад байна гэсээр дэгдээхийнүүд үүрэндээ толгойгоо улам лав шургуулжээ.

Бусад өдрүүдэд ч гэсэн хүүхдүүд гадаа гардгаараа гарч дэглийнүүдийг хараад дуулдгаараа дуулсаар...



... Цөлмөж тэгвэл бид нэгийг нь шонгоос дүүжилнэ

Цееремд хаяж нөгөөгий нь живүүлнэ

- Тэгэхээр биднийг дүүжилж живүүлэх нь ээ гэж дэгдээхийнүүд шалгаав.

- За за, хаанаас. Бид удахгүй дасгал сургууль хийж эхлэх болно. Та нар бүгдээрээ нисч сурах хэрэгтэй байна. Та нарыг нисч сурангуут хэдүүлээ мэлхийтэй нугад зочлон очигцооно. Мэлхийнүүд та бүхний өмнө усан дотроо "вааг вааг вааг" хэмээн дуулалдацгааж байх болно. Бид тэд нараас идэцгээн ямар хөгжилтэй сайхан байцгаана гэж та нар бодно оо!

- Дараа нь бид яах вэ гэж дэгдээхийнүүд асууцгаав.


- Дараа нь дэглий бид нар намрын аяндаа бэлдэцгээнэ. Тэгэхлээр мэдээж зайлшгүй нисч чаддаг байх ёстой. Энэ бол тун чухал зүйл шүү. Хэн муу ниснэ, түүнийг генерал хурц хошуугаараа хатган шийтгэнэ. Та нар сургууль эхлэхээр хичээж үзээрэй.

- Тэртэй тэргүй хүүхдүүд биднийг хатгаж алах юм чинь. Чагна л даа, тэд дахиад л дуулалдаад эхэллээ.

- Тэднийг битгий сонс. Миний юу гэхийг анхаарцгаа. Дасгал сургуулийнхаа дараа бид холын хол, өндөр өндөр уулын цаана Египетийн өтгөн ой мод, дулаан газар очигцооно. Тэнд гурвалжин хэлбэрт чулуун байшингууд байдаг. Тэдний орой үүлэнд тулаад, ямар өндөр гэж бодно. Тэдгээр байшинг пирамид гэдэг юм. Пирамидууд ганц ч дэглий өөрснийгөө ямар байсныг мэдэхгүй тэртээ эрт цагт баригдсан юм. Тэнд бас үерлэхээрээ эрэг нь нэл лаг шавар болдог сонин мөрөн байдаг. Лаг дунд нь буухад нэл мэлхий, ханатлаа зооглоход харин ч нэг болно доо.

- Яасан сайхан юм бэ гэж дэгдээхийнүүд дуу алдацгаалаа.





- Тийм ээ. Жинхэнэ гайхамшиг гэгч тэр шүү. Тэгэхлээр тэнд өдөр бүр идээд л байна, идээд л байна гэсэн үг. Биднийг тэнд тийм сайхан жаргаж байхад эндхийн моддын мөчирт ширхэг ч навч үлдээхгүй аймшигтай хүйтэн болж, үүлс хөлдөн газарт жижигхэн жижигхэн үртэс болон унаж байх болно.

Ийнхүү эх дэглий цасны тухай үрсдээ ярьж өгөхийг хүссэн боловч хараахан сайн тайлбарлаж өгч чадахгүй байжээ.

- Тэгвэл энэ муухай хүүхдүүд бас хөлдөх үү гэж дэгдээхийнүүд сонирхов.

- Үгүй ээ, хөлдөхгүй. Гэвч эд нар үхтлээ даарна. Гэрээсээ хамраа цухуйлгах ч зориг нь хүрэхгүй, харанхуй өрөөнүүддээ уйтгарлан сууцгаах болно. Тэгэхэд та нар цэцэг алаглаж дулаан нар туяарах холын нутагт нисэцгээж явна шүү дээ!

Өдөр хоног жаахан өнгөрөхөд дэгдээхийнүүд өсч томрон үүрэн дотроо зогсож, эргэн тойрныг сонирхон харцгаах боллоо. Эцэг дэглий тэдэндээ хачин гоё амттай мэлхий, гүрвэл өөр бас сонин гоё юу л байна олж чадах бүгдээ авчран дайлна. Бас ямар олон шинэ шинэ юмаар дэгдээхийнүүдээ саатуулан зугаацуулдаг гэж бодно оо. Толгойгоо сүүлэндээ хэрхэн хүргэх, хоолойдоо тогшуур хөгжимтэй юм шиг хошуугаараа хэрхэн дуугарах зэргийг биеэр үзүүлж, намагт болсон элдэв сонин хачин явдлын тухай ярьж өгч байлаа.

Тэгтэл нэгэн сайхан өдөр ээж нь дэгдээхийнүүддээ “Хичээлдээ орох цаг боллоо” гэж хэлэв. Дөрвөн дэгдээхий үүрнээсээ байшингийн дээвэр өөд гарах хугацаа болжээ. Бурхан минь! Тэд далавчаараа биеэ арай гэж тэнцүүлж золтой л уначхалгүй, яаж тэвдэцгээж байсан гэж бодно.

- Алив над уруу хараарай гэж ээж нь захирав. Толгой ийм,

хөл ийм байх ёстой. Нээг хоёр, нээг хоёр. Та бүхнийг амьдралын замд ороход чинь энэ бүхэн туслах болно. Ээж нь ийнхүү хэлж далавчаа хэдэнтээ дэвж үзүүлэв. Дэгдээхийнүүд эв хавгүй үсрэн харайцгааж, “Зогсоод” гэсэн дуу хадаж, нисэх сургууль нь зөндөө сунжирчээ.

- Би үүнийг сурмааргүй л байна. Тэр дулаан орон уруу чинь би ерөөсөө нисмээргүй байна гэж дэгдээхийнүүдийн нэг нь хэлэв.

- Тэгээд чи энд өвөл хөлдөж үхье гэж бодоо юу? Нөгөө хүүхдүүд ирж чамайг дүүжлээсэй, живүүлээсэй, эсвэл шатаагаасай гэж хүсээ юу? Тэгвэл чи хүлээж бай. Би тэднийг дуудаатахъя.

- Үгүй үгүй, тэгвэл... Тэд дахиад дээвэр дээр гарч дэгдэн харайж эхлэв. Дэгдээхийнүүд сургуулийн гурав дахь өдрөө ямар нэг хэмжээгээр нисч учрыг нь олцгоов. Тэр байтугай далавчаа дэлгэсэн хэвээр агаарт тогтож сурсан байлаа. “Нээрээ далавчаа цаг ямагт дэвэхийн хэрэг юу байна” хэмээн дэгдээхийнүүд хоорондоо ярьж, одоо амарвал боллоо гэгцгээж байв.

Энэ маягаар сургуулиа цааш нь үргэлжлүүллээ. Гэм нь үе үе далавчаараа дээвэр алгадах явдал гараад болж өгсөнгүй. Тэгэхлээр дахиад л далавчаа хэрхэн ажиллуулах тухай ажил гарав. Энэ үед нөгөө жаалууд мөн л гудамжинд цуглан “Дэглий дэглий, цагаахан дэглий шувууд аа...” хэмээн дуулалдах сонстоно.

- Бид нисч очоод тэдний нүдийг сох тоншиж болох уу гэж дэгдээхийнүүд асуув.

- Яах юм бэ, тэгж хэрэггүй. Хэрэгтэйгээр нь над уруу харцгаа. Нэг, хоёр, гурав! Нэг, хоёр, гурав! Одоо баруун тийшээ нисээрэй. Нэг, хоёр, гурав! Нэг, хоёр, гурав! Одоо зүүн тийшээ, тэр янданг тойроод нисээрэй. Зүйтэй! Та нарын сүүлчийн дэвэлт гайхамшигтай сайхан боллоо. Тэгэхлээр маргааш та нарыг надтай цуг намаг орохыг зөвшөөрч байна. Тэнд өдий төдий олон сайхан сайхан гэр бүл, хүүхдүүдтэйгээ байж байгаа. Тэдэнд өөрснөө ямар дэгдээхийнүүд вэ гэдгээ үзүүлцгээ дээ. Ээж нь та нарыгаа тэдний дунд хамгийн хөөрхөн, хамгийн сайн нь байгаасай гэж үнэхээр хүсч байна. Толгойгоо дээхнүүр, ёстой нэг гоёхон байцгаагаарай.

- Тэгээд бид нар тэр муухай жаалуудаас өшөөгөө авахгүй юм уу гэж дэгдээхийнүүд шулганав.

- Яадаг юм, тэд юу л гэнэв хашгирч л байг. Тэгэхэд миний хүүхдүүд та нар гайхамшигт пирамидын орныг үзэцгээх юм чинь. Харин цаадуул чинь эндхийнхээ өвлөөр даарч бээрэн, нэг ч ногоон навч, ганц ч амтат сайхан алимны бараа харахгүй сууцгаах болно.

- Тэгэхдээ ямар ч байсан бид нар өс хонзонгоо заавал авна даа гэж дэгдээхийнүүд зүтгэсээр нисэх сургуулиа үргэлжлүүлжээ.

Хүүхдүүдээс хамгийн бага нь, хамгийн дүрсгүй байлаа. Тэр л дэглий шувуудын тухай дууг хамгийн анх эхлэн гаргасан юм. Хэдийгээр "Тэр магад зуун нас хүрсэн байх, миний аав ээжээс ч ах настай" гэж дэгдээхийнүүд бодсон ч хүү зургаан наснаас хэтрээгүй байжээ. Нээрээ ч хүмүүс, тэдний хүүхдүүдийн насыг хаанаас олж мэдэх билээ. Дэгдээхийнүүдийн хамаг дургүйцэл, хамгийн өршөөлгүй, өөрсдийг нь дооглон тохуурхсан, тэр бүх явдлыг эхлэн өдөөсөн хүү үрүү голлон чиглэжээ.

Бяцхан дэглийнүүд өсч томрох тусмаа түүнийг өршөөхгүй гэж хатуу шийдсэн байлаа. Үүний учир "Жаал хүүгээс өс хонзонгоо ямар нэг аргаар ав. Тэгэхдээ бүгдээрээ халуун орон уруу нисэхийнхээ яг өмнөхөн ав" гэж эцсийн эцэст эх дэглий дэгдээхийнүүдэд зөвшөөрөв.

- Тэгэхдээ та нарыг эцсийн сургууль дасгалдаа хэрхэн оролцохыг чинь урьдаар харна. Муу байвал цувааны ахлагч хошуугаараа элгээд чинь ёворно. Тэгээд бас хүүхдүүд яах ч үгүй үлдэх болно. Чингээд та нарын ямаршуу байхыг чинь харж байя даа.

- Харуулна даа, бид гэж дэгдээхийнүүд бүгд хэлэнгүүтээ дасгал сургуульдаа хичээнгүйлэн орцгоолоо.

Сургуулилт өдрөөс өдөрт улам сайжран дэгдээхийнүүд дорхноо газраас хөөрөн, хараад ханашгүй гоёор нисэцгээдэг боллоо. Намар болж дэглийнүүд дулаан орноод нисэн одохоор бэлтгэж эхэллээ.

Дэглийнүүд хөвч ой, ус нууруудын дээгүүр хөндлөн гулд нисч,



тэднийг хүлээж байгаа агуу их аян замд базааж байв.

- Одоо л өсөө авдаг цаг гэж дэгдээхийнүүд дахиад санал гаргалаа.

- Зүйтэй. Би нэг зүйлийг бодож оллоо. Энэ нь ч дээр байх гэж бодож байна гээд ээж нь ярилаа.

- Жаалхан хүүхдүүдийг дэглий шувуу ээж аавд нь авчирч өгөхийг хүртэл хүүхдүүд дотор нь унтаж байдаг нэгэн цөөрмийг би мэднэ. Тэнд жигтэйхэн хөөрхөн хүүхдүүд хачин гоё зүүд зүүдлэн, жаргалтайяа нойрсоцгоож байдаг юм. Бүхий л аав ээж нар тийм жаалтай, бүх хүүхдүүд тийм хөөрхөн дүү нартай болдог ч болоосой гэж хүсдэг юм. Тэр гайхамшигт цөөрөм үрүү нисэн хүрцгээж, тэр жаалуудаас нэгийг нь авчраад дэглий шувууд биднийг доромжилдоггүй хүүхдэд авчирч өгье. Харин өнөөх муу жаалуудад юу ч өгөхгүй.

- Тэгвэл, биднийг эхлээд доромжилдог жаалд юу өгөх вэ гэж залуу дэглийнүүд шалгаав.

- Тэр цөөрөмд үүрд унтаж хоцорсон бас нэг жаал байдаг. Түүнийг тэр хорон санаатай хүүд авчирч өгнө. Надад унтаа жаал авчирч өглөө гэж мэдээд уйлбал уйлаг, хамаагүй. Та нар хэрвээ

мартаагүй бол “Амьтдыг тохуурхан доромжлох нүгэл” гэж хэлдэг нөгөө сайн санаат хүүд бид нэгмөсөн хүү, охин хоёр дүү авчирч өгнө. Тэр хүүг Петер гэдэг юм. Тийм учраас түүнийг хүндлэн дурсаж, бид бүгдээрээ өөрсдөө Петер гэдэг нэртэй болцгооё оо.

Эх дэглийн ярьсан бүгд ёсоор болж бүх дэглий цөм Петер гэдэг нэртэй болцгоов.

Дэглий шувууг Петер гэж хааяа бас нэрлэдгийн учир энэ гэнэ ээ.

Гахай- мөнгө хураагуур

Хөөрхөн хөөрхөн хүүхдүүдийн хөгжилтэй олон тоглоом байжээ. Хөгжилтэй тэр олон тоглоомон дундаас хамгийн өндөрт, тусгай шүүгээн дээр хүндтэйгээр залардаг нь “Гахай- мөнгө хураагуур” хэмээх мөнгөний сав байж гэнэ.

Хураагуурын ар нуруунд жаахан нүхтэй, томоохон зоос хийхэд амар гэж түүнийг нь тонгоргийн ирээр бага зэрэг томруулсан байлаа. Гахай-мөнгө хураагуурт аль тэртээ цагт хийсэн том гээчийн хоёр зоосноос гадна өчнөөн олон задгай мөнгө хийсэн тул пиг дүүрч, савтай мөнгийг сэгсрээд сэгсрээд жингэнэж дуугарахаа ч больсон байжээ.



Гэдэс нь тийм айхтар дүүрсэн гахай шүүгээн дээрээс эргэн тойрноо сүртэй харж, харсан болгоноо худалдан авъя гэсэн ч санааны дур болсон учир сэтгэл нь нэн чиг хангалуун байх болж гэнэ. Тэр тухай тоглоомууд бүгд мэддэг боловч хоорондоо юу ч ярилцахгүй байцгаана.

Суудал-шүүгээний нэг нүд хагас онгойж дотроос нь том гэгчийн хүүхэлдэй унасан

хэвтэнэ. Хүүхэлдэй хэдийнээ хөгширч хүзүүгий нь цавуудан тогтоожээ. Тэр хүүхэлдэй эргэн тойрноо харснаа,

- Хүн болж тогловол яасан юм бэ, та минь. Зүгээр байгаад байсанд орвол ямар нэг юм хийцгээе л дээ гэж санал гаргав.

Үүнийг сонсоод бөөн шуугиан үүслээ. Урьд нь хэн нэгэнтэй энэ тухай маргаж санал зөрж байгаагүй ч хананд хадсан зурагнууд хүртэл дуу оржээ.

Шөнө дунд болж гэгээ гэрлээ бүхэнд хайрлахыг хүссэн сар бүх айлын цонхоор тусч байлаа. Тэдний энэ удаагийн тоглоомд бүх наадгай бүгдээрээ уригдаж "Хэтэрхий эв хавгүй, том" гэж тоглоомуудын доод зиндаанд ордог хүүхдийн сүйх тэрэг хүртэл ирсэн байв.

- Ямар ч юм өөрөө өөртөө л сайхан. Хэн бүхэнд таалагдахгүй байж болно л доо. Гэхдээ олны хэлдгээр бусдад тустай байх нь л гол зүйл гэж сүйх тэрэг хэлээд авлаа. Тэр олон тоглоомуудаас ганцан мөнгөөр дүүрсэн гахай л хүндтэй бичмэл урилга хүлээн авчээ. "Хураагуур- гахай тэртээ өндөрт суудаг хойно амаар уриад сонсохгүй биз" гэж тоглоомууд бодоод тэгж шийдсэн байжээ.

Урилга авсан хураагуур хүрэлцэн ирэх эсэхээ ядаж мэдэгдсэнгүй. Ирэхгүй ч байж мэдэхээр болоод явчав. Гэвч тэгсэнгүй ээ. Харин,

- Та нар намайг наадам тоглоомдоо оролцуулъя гэж хүсэцгээж байгаа юм бол би бүхнийг өөрийнхөө суудал дээрээс харж байхаар тоглоомоо зохион байгуул гэж Гахай-хураагуур хэлсэн байна.



Тоглоомууд бүгдийг тэр ёсоор болголоо. Түүний байнга суудаг шүүгээний нь өмнө хүүхэлдэйн театрын тайз засчээ. Хураагуур-гахайд тайзан дээрх бүх явдал алган дээр нь байгаа юм шиг илхэн харагдаад, таатай ажээ.



Эхлээд шог хошин үзэгдэл тоглоцгоох гэснээ дараа нь хоол унд ууж идэж, хоорондоо ярьж хөөрөх юм болов. Ингээд яриандаа орцгоожээ.

Тоглоомон морь адуу, уяа сойлго, цэвэр үүлдрийн адууны тухай тоочин ярилаа. Хүүхдийн сүйх тэрэг, төмөр зам, уурын тэрэгний хүчний тухай, тэдгээрийн эд эрхтний талаар яриу. Тасалгааны цаг,

- Түг түг, улс төрийн ажилд гарамгай авьяастай, хэзээ чухам явал зүйтэйг анддаггүй гэлээ. Харамсалтай нь бусад тоглоомууд тэдний тухай хорон үг гаргасаар байгаад огцруулчихсан ажээ. Хулсан таяг өөрийнхөө төмөр гутал, мөнгөөр хийсэн малгайгаар онцгой их бахархаж байлаа. Тэр дээрээсээ ч, доороосоо ч тэгж битүү гоёж, хамгаалсан юм чинь өөрөөрөө бахархах нь зөв байлгүй явах.

Буйдан дээр хөөрхөн, муухай хоёр оёмол жинтүү хэвтэж байлаа. Энэ хоёр жинтүү ямар ч л гэсэн хэн хэндээ ижилсэн дасчээ. Тоглоомууд бүгд эгнэн зогсч, өмнөх үзэгчиддээ хандан өөр өөрсдийг нь сайшааж байгаагаа илэрхийлэн хариу талархаж гараа инчдэх, хашгирах зэргээр тоглолтоо идэвхжүүлэхийг хүсч байлаа.

Гэтэл үүнийг сонссон сүлжмэл хогийн шүүр:

- Гэрлээгүй, угсаа сайтай хатагтайд гэхээс биш аль нэг хөгшин авгайд бол би талархаж чадахгүй гэж тэр дороо эсэргүүцэв.

- Би бол бүгдээрэнд чинь талархана гэж бууны сумны бялт ёс төртэй мэдэгдлээ.

"Хаа ч явсан өөрийнхөө л бодлоор байх нь зөв" гэж нулимур дотроо бодлоо. Тоглоом болгонд өөр өөрийн бодол байлаа. Хошин шог нь гавиагүй боловч хосгүй сайн тоглох



нь ч тогложээ. Үүнээс гадна жүжигчин бүхэн өөрийгөө онцгой сайн тоглосон гэж бодовч тэд нэгэнт олны өмнө татсан урт хэцэн дээр тоглосон тул хэрхэн жүжиглэсэн нь бүхнээ ил байжээ. Жүжигчид юмыг дандаа сайн сайхан талаас нь үзүүлсэн тул үзэгчдэд юмсын цаад учрыг нь ойлгох боломж үнэндээ гараагүй юм байжээ.



Цавуудсан хүүхэлдэйн сэтгэл нэн их уярсан тул цавуугаараа салахаа шахаж, мөнгөөр дүүрэн гахайд гэдсэн дэх баялаг нь тун аятайхан санагдаад "Жүжигчдийн нэгэнд ямар нэг буантай үйл бүтээе. Тухайлбал, хэзээ нэгэн цагт өөрөө орчлонгоос буцахаа болохоор тэрхүү жүжигчнийг өөртэйгөө хамт оршуулагтун гэж гэрээслэе байз" гэж бодотхожээ.

Ер нь л бүх тоглоом иймэрхүү, бүгд баярлаж хөөрсөн сэтгэлдээ дийлдэн, үүнээс болоод цайлцгаах гэснээ хүртэл больж, түрүү тохирсноор хүн болж тоглохоор шийдэн шууд яриа хөөрөөндөө орцгоолоо.

Харамсалтай нь өчүүхэн ч гэсэн хөгжиж завдсангүй. Тэд дөнгөж тоглож эхэлсэн ч мөнгөний хураагуур гахай өөрийн тухайд хэрхэн бодолхийлсэн шиг тоглоом бүр мөн л өөрсдийн хувь заяаны талаар санагалзаад, юун тоглохтой мантай. Энэ үес Гахай-хураагуур "орчлонгоос буцах цаг"-ийнхаа тухай болоод гэрээслэлийнхээ талаар лавшруулан бодож эхэлтэл... тоогүй юм болох нь тэр.



Үхэл зовлон ямагт бодож байснаас түрүү ирдэг ажээ. Хураагуур- гахай шүүгээн дээрээс гулсан унаж, бут үсрэн том зооснууд шалан дээгүүр хэдэнтээ дэгдэн гүйв.

Жижигхэн задгайнууд маш хурдан, том нь аажуухан өнхрөлдөв. Ялангуяа "Өөрөө хүмүүсийг үзэх, өрөөлд харагдахсан" гэж ихэд хүссэн нэг зоос ганцаараа зөндөө удаан эргэлдэн өнхөрчээ.

Тэр зоос ийнхүү дэлхийгээр нэг аялахаар гарч, бусад нь ч ялгаагүй мөн л аян замдаа орох нь тэр байлаа. Харин гахайн гэдсэн дотроос жижигхэн өт гарсныг хэн нэг нь аваад хогийн саванд хийчхэв.

Энэ явдал болсны маргааш бас нэг Хураагуур- гахайг шүүгээн дээр шинээр авчраад тавьчихсан байжээ. Одоогоор түүний ходоод зайтай байгаа ч мөн л хонгиноод байхааргүй болсон нь өмнөх Хураагуур-гахайтайгаа аанай л төсөөтэй буюу. Эхлэл маань одоогоор хангалттай тул яриагаа төгсгөө.

Чин үнэн явдал

Хэрэг явдал болсон газраас хаа хамаагүй хол, хотын бүүр захад байдаг нэгэн эмэгчин тахиа:


- Тэнд нэг тахианы байранд ёстой муухай явдал болж гэнэ ээ та минь. Би түүнийг сонсоод ганцаараа хонохоос ч айж орхилоо гэм. Манайх ам бүлээр өнөр тулдаа л санаа жаахан амарлаа гэжээ.

Эмэгчин тахианы энэ яриаг сонссон хамаг тахиа айсандаа өд сөд нь босч, эрэгчин тахианы залаа хүртэл налмайтал буугаад ирэх шиг боллоо.

Арга байж уу, эмэгчин тахианы яриа чин үнэн гэсэн шүү дээ.

Чухам юу болсныг одоо эхнээс нь ярьж өгье.

Дээрх явдал хотын нөгөө захын тахианы байранд анх болжээ.



Юу болоо вэ гэхээр нар хэдийнээ жаргах болж тахианууд саравчныхаа хөндлөвч дээр гарчихсан сууцгааж байжээ. Тэдний нэг богинохон хөлтэй цагаан тахиа аль ч талаараа зохистой аятайхан, нэр хүндтэй, өндөг сайн өгдөг, тун ч үлгэр жишээ тахиа юм санжээ. Тэр энэ удаа унтаж амрахынхаа өмнө тухлан суугаад, өд сөдөө хошуугаараа цэвэрлэж янзалж байжээ. Тэгтэл биенээс нь жижигхэн өд сугараад шалан дээр уначхав гэнэ.



- Хүүе ээ, хайран өд минь уначихлаа. За яахав, ямар ч гэсэн хэчнээн л цэвэрлэнэ, би төчнөөн гоё болох юм чинь гэж цагаан тахиа хэлсэн гэнэ.

Энэ үгийг уулаасаа хөгжөөн наргиантай, бусдадаа нэр хүндтэй тахиа зүгээр л тоглоом болгон хэлж л дээ.

Удалгүй тахианууд түрүүчээсээ унтаж эхэллээ. Тахианы байранд харанхуй болжээ. Харин цагаан тахиатай зэрэгцэн сууж байсан тахиа л унталгүй хоцорчээ. Тэр хөршийнхөө яриаг зориуд чагнаагүй боловч хальт сонссон юм байж. Тэгээд бас энэ ертөнц дээр хамгийн ойр дотны найз хэн бүхэнд байдаг хойно доо. Үүнээс ч болов уу, тэр нөгөө талын хөршдөө хандаж хэлсэн нь:

- Хөөе, чи сонсов уу? Би түүний нэрийг хэлээд яахав. Гэхдээ үзэсгэлэнтэй сайхан харагдах гэж бүх өдөө зулгаахаа ч сийхгүй нэг тахиа бидний дунд байна гээд чи бод доо. Би хэрвээ эрэгчин тахиа юм сан бол тийм амьтныг ёстой өрөөсөн нүдээрээ ч тоож харахгүй дээ.

Энэ үед бас тэр тахианы байрны яг дээр нэгэн шар шувуу нөхөр, хүүхэдтэйгээ амьдардаг байжээ. Шар шувууны чих тун айхтар соргог тул саяын яриаг ганц ч үг гээлгүй сонсчихсон байжээ. Шар шувууд гайхан нүдээ эргэлдүүлэхэд эх шар шувуу далиа матигануулан хэлсэн нь:



- Чишш, чимээгүй, миний хүүхдүүд ээ, бүү чагнаарай. Гэвч та нар аль хэдийн сонсчихсон уу? Би ч бас сонсчихлоо. Чихэндээ ч итгэмээргүй явдал байна даа. Нэг эм тахиа эр нөхрийнхөө нүдэн дээр өдөө хэнэг ч үгүй маяглан зулгаасан гэнэ шүү гэжээ. Тэгэхэд нь эцэг шар шувуу:

- Алив дуугаа аяд гэм. Хүүхдүүд сонсчих вий. Иймэрхүү юмыг хүүхдүүдэд дуулгах ёсгүй. Тэгэхдээ ямар ч гэсэн энэ тухай хөрш шар шувуундаа ярих хэрэгтэй юм аа гэчихжээ.

- Үүний маань ааш зан ямар ялдамхан гэж санана аа гэж хэлснээ, эм шар шувуу хөршийнх үрүүгээ нисэн оджээ. Дараа нь тагтааны үүрний дээхнэ хоёр эм шар шувуу нийлж аваад,

- Хүү-хэг, хүү-хэг. Хүүе, чи сонсов уу? Сонссон уу, үгүй юу? Нэг эмэгчин тахиа эрэгчин тахианаас болоод хамаг өд сөдөө зулгаачихсан гэнэ шүү дээ. Тэр өдийд даараад хөлдөж үхсэн ч байж магадгүй байх аа. Хөлдөхгүй ч гэсэн дээ... Хүү-хэг, хүү-хэг гэлцлээ. Энэ яриаг тагтаанууд өлгөж аваад,

- Эм тахиа, ингэж ингэж гэнэ ээ. Эм тахиа гэж үү, хаана тэр вэ? Хөөе, хаана ийм явдал болоо вэ гэлцлээ.

- Манай хамар хашаанд гэм дээ. Бараг намайг харж байхад ийм явдал болсон юм чинь. Ярихад ч эвгүй юм аа. Гэхдээ аргагүй л ийм явдал болсон юм шүү.

- Таны үгэнд итгэлгүй яахав, итгэлгүй яахав гэж тагтаанууд бувтнаад, тэдний доор амьдардаг эм тахианд хэлжээ.

- Нэг эмэгчин тахиа, үгүй ээ бүүр хоёр ч эмэгчин эрэгчиндээ үзэсгэлэнтэй гоё харагдах гээд хамаг өд сөдөө зулгаачихсан гэнэ ээ, цаана чинь. Мөн ч муухайяа даа. Тэр аягүй бол салхинд цохиулаад үхээ биз. Өдийд аягүй л бол үхсэн байхаа даа гэлцлээ. Эрэгчин тахиа хашаан дээр гараад,

- Гүг гүүг, гүг гүүг! Сэрээрэй, та минь гэж өөрөө ч нойрмог, нүд нь аниастай чигээрээ хашгирлаа.

- Азгүй дурлалаасаа болоод гурван эм тахиа амиа алдсан байна, та минь ээ! Бүгдээрээ өд сөдөө зулгааж үхсэн юм байна.

Юу гэзчийн булай явдал гэзч вэ. Ийм юм болж байхад би яаж дуугүй байж чадах вэ. Үүнийг ертөнцийн хамаг амьтан сонсч, мэдвэл таарна гэж орилов.

- Мэдэх ёстой, тэгвэл таарна! гэж сарьсан багваахай, эрэгчин, эмэгчин хамаг л тахиа дэмжин орилж бархирчээ.

Ийнхүү тэр явдлын тухай цуурхал хашаанаас хашаа уруу, тахианы нэг байрнаас нөгөө үрүү явсаар, анх эхэлсэн газраа хүрч иржээ.

- Таван эм тахиа эрэгчиндээ дурлаж, дурлалдаа согтсоноос болж хэн нь илүү турж, гоолиг сайхан болсноо үзүүлэхээр өд сөдөө зулгаасан гэнэ ээ. Тэгээд бие биенээ үхтэл тоншиж зовоосон юм байх аа. Ингэж угсаа төрлөө гутааж, эзэндээ гарз гаргана гэж ер нь байж болох уу гэлцэж байв.

Харин нөгөө ганц өдөө унагасан тахиа энэ бүх түүхийг яаж мэдээ аж. Аль ч талаар эрхэм хүндтэй тэр:

- Энэ муусайн эмэгчин тахиануудыг би үзэн ядаж байна. Гэхдээ тийм өөдгүй худалч амьтан даанч олон доо. Тэдний тухай л дуугүй сууж болохгүй. Би ч гэсэн энэ явдлыг сонин хэвлэлд гаргахыг хичээнэ. Энэ муусайчуул, тэдний омог угсааныхан бүгд сонин хэвлэлээр дамжиж, бүх дэлхийгээр муу муухайгаа дуудуулбал таарна гэж өгүүлжээ.

Энэхүү болсон чин үнэн явдлын түүх үнэхээр сонин хэвлэлд гарсан юм. Ганцхан ширхэг бяцхан өд тавын таван эм тахиа болон хувирахад мөн ч амархан болсон цаг юм даа, хөөрхий.



Жаргалтай ам бүл



Манай улсад ургадаг навчсаас хамгийн том нь даливсын навч биз ээ. Даливсын навчийг та өмнөө барихад хормогч болдог бол бороонд толгой дээрээ барьж гэмээ нь шүхэр болох жишээтэй билээ. Даливс гэдэг маань иймэрхүүл ургамал даа.

Тэгээд бас даливс ганцаараа ургана гэж ер үгүй, өнчин ганцаар ургасан мэт харагдавч түүнийг тойроод өдий төдий ургамал ургадаг байна. Ургасан тэр бүхэн цөмөөрөө эмгэн хумсын хоол хүнс болдог гэж байгаа. Том том цагаан өнгөт эмгэн хумсаар эрт дээр үеэс эхлээд дээдэс ноёд, хөвүүртэй шөл хийж, хосгүй сайхан амтыг нь гайхан дуу алдацгаадаг байв. Мөнөөх том том, цагаан цагаан эмгэн хумс нь даливс өвсөөр хооллох тул хүмүүс арвин их даливс тариалах болсон ажээ.

Гэтэл эмгэн хумс нь барагдсан тул эндхийн нэгэн ноёны хот айл эмгэн хумс идэхээ огт больсон байна. Харин даливс өвс нь хэзээ ч барагдаж сөнөсөнгүй, юунд ч үл дийлдэн хаа сайгүй ургаж хяр гүвээ, талбай цэцэрлэгт нил даливс сагсайж, цэцэрлэг гэхэд хэцүү, даливсан ой болжээ. Хэрвээ тэнд ганц нэгхэн алимны, чавганы бут байгаагүй сэн бол урьд нь энд цэцэрлэг байсныг хэн ч тааварлах аргагүй болсон байна.

Одоо энэхүү даливсын ойд хөгширч гүйцсэн сүүлчийн хос эмгэн хумс амьдрах болжээ. Тэд өөрсдийгөө хэдэн настайг үл мэдэвч, "Урьд нь эмгэн хумснууд маш олуулаа байсан, өөрснөө тэртээ дээр үед гадаад оронд үүсч төрсөн, энэ хавийн их ойг зөвхөн өөрсдийнх нь тусын тулд тарьж ургуулсан" гэдгийг сайтар санаж байжээ. Хөгшин эмгэн хумснууд төрөлх дотно ойгоосоо хаашаа ч гардаггүй, сахин суудаг байна. Хэдийгээр тийм боловч "Ноёныхны



хот айл” гэдэг нэгэн газар байдаг, тэнд эмгэн хумсыг хаттал чанаж, дараа нь тогооноос гарган мөнгөн царан дээр тавьдаг гэж эрхибиш муухан мэддэг байв гэнэ ээ.

- Тэгээд цааш нь яадаг бол? Мэдэхгүй юм аа гэгцээнэ. Тэр чанагдаж гүйцнэ гэгч яахыг хэлдэг, мөнгөн царанд гаргана гэж яадаг юм бэ гэдгийг бас үл мэднэ. Харин юу мэддэг байсан бэ гэвэл тэр маш гайхамшигтай сонин юм байдаг, гол нь эрхэм дээд угсаатны л явдал байх гэж санадаг байсан юм байна.

Тэр тухай тавдугаар сарын цох, мэлхий, чийгний улаан өтний хэнээс нь ч асуусан чухам юу байдаг, яахыг хэлдэг талаар хариу юу ч хэлсэнгүй. Яагаад вэ гэвэл тэдний хэн нь ч чануулж, тогооноос гаргуулан мөнгөн царан дээр тавиулж үзээгүй билээ.

Хөгшин цагаан эмгэн хумснууд өөрсдийгөө ертөнцөд алдар цуутай бүхий л ой тэдний тулд ургадаг, ноёны хотынхон тэднийг чанаж, мөнгөн царан дээр тавих л гэж өөрснөө заяагдсан юм гэдгийг гадарладаг байлаа.

Эмгэн хумснууд хоорондоо эвтэй найртай, тэрхэндээ чимээ шуугиан ч үгүй ихэд жаргалтай амьдарч байлаа. Тэд өөрийн төрсөн хүүхэдгүй тул ерийн нэгэн хөршөөсөө хүүхэд үрчлэн авсан байна. Эмгэн хумс түүнийг өргөж авахдаа өсч үржээсэй гэж бодсонгүй. Учир нь тэр бол эгэл жирийн, ердийн үүлдрийн эмгэн хумсны удам юм.

Хэдий тийм боловч хүү нь илт өсч томроод байх шиг хоёр хөгшинд, ялангуяа ээж эмгэн хумсанд санагдсан тул тэр эцэг эмгэн хумсанд “Чи үүнийг ажиглаагүй бол хүүгийнхээ хуягийг тэмтрээд үзээч” гэж хүсчээ. Эцэг эмгэн хумс хүүгийнхээ хуягийг тэмтэрч үзээд гэргийнхээ үгийг бүрнээ зөвшөөрсөн байна.

Айхтар ширүүн бороо цутгаж байлаа.

- Аа яа яа, даливсан дээр ч мөн бөмбөрдөж байх шив ээ гэж эцэг эмгэн хумс хэлэв.



- Пээ, ямар том дуслууд вэ. Цэцгийн дэлбээнээс ус урсаж байхыг нь хараач. Одоо яасан хүйтэн болох бол оо. Бид нар, манай хүү ч гэсэн өөрсдөдөө тийм бөх бат байшинтай гэж санахаас би хэчнээн их баяртай байна вэ. Энэ ертөнцийн өөр хэнд ч байдаггүй сууц бидэнд заяасан юм аа. Ертөнцөд ийм сайхан байшинтай болсон анхны амьтад бид нар л юм. Бид төрсөн цагаасаа эхлээд өөрийн гэртэй, бидний төлөө бүхэл бүтэн даливсан ой ургажээ. Харин энэ ой хаа хүртэл үргэлжилдэг бол, ойгоос цааш юу юу

байдаг бол, мэдэх юм сан гэж эх эмгэн хумс хэлжээ.

- Яршиг цаашаа. Эндээс илүү сайхан газар өөр хаа ч байхгүй. Түүнийг чинь би л лав явж эрэхгүй гэж эцэг эмгэн хумс дуугарав.

- Миний хувьд бол тэр бууцыг олж, чануулж, мөнгөн царан дээр тавиулж үзмээр л байна. Ийм завшаан манай өвөг дээдэс бүгдээрэнд олдсон билээ. Үүнд нэг л эрхэм чухал нууц байгаад итгэх хэрэгтэй биш үү гэж эх эмгэн хумс зөрлөө.

- Ноёныхны бууц аль хэзээний устаж алга болсоон. Эсвэл даливс битүү ургаад, замыг нь хааж, хэн ч гарах орох аргагүй болж гүйцээ биз. Ер нь чи юундаа яараа вэ? Дандаа л яарч байх юм чи!

- Хүү маань, чиний өмнөөс тийшээ яваад ирвэл яасан юм бэ. Цаадах чинь цэцэг навчин дээгүүр гурав дахь өдрөө шал дэмий мөлхөж өнжлөө. Харахаас бүүр толгой эргээд байх юм.

- Хүүгийг минь битгий яншаад байгаач! Их болгоомжтой мөлхдөг юм чинь. Үхэх нь болсон бидэнд гол зугаа хүү минь л болж байна. Харин чи түүнд хаанаас бэр буулгахаа бодсон санасан юм байна уу? Даливсын ойгоос цааш бидний ижил төрлийнхнөөс хэн нэгэн олдох бол, чи юу гэж бодож байна аа?


- Гэргүй хар эмгэн хумснууд байгаа л даа, тэнд. Гэвч тэд чинь эгэл доод гаралтай болохоор яаж болдог юм. Тэгээд бас тэдний үнэрхүүгий нь яана гээ. Ер нь энэ ажлыг шоргоолжнуудад даалгавал яасан юм бэ. Тэд үргэлж нааш наашаа холхиж байдаг болохоор хүүд минь авгай эрж олог гэв. Үүнийг шоргоолж сонсоод,

- Өө, саналаа саналаа. Би нэг их царайлаг охиныг мэднэ. Гэхдээ тэр танайхыг тоож ирэх болов уу, үгүй болов уу. Тэр чинь ноён угсаатай шүү дээ гэж хэлэв.

- Өө, тэр ч гайгүй байна аа. Тэр өөрийн орон гэртэй юм уу гэж эцэг эмгэн хумс асуув.

- Орон гэрээр барахав. Бүүр тансаг ордтой гээч. Шоргоолжнууд бүгдээрээ амьдардаг гайхамшигтай сайхан нүхтэй билээ.

- Танд чин сэтгэлээс талархъя. Тэхдээ хүү минь шоргоолжийн нүх рүү мөлхөж явна гэж юу байсан юм? Түүнээс дээр юм та нарт олдохгүй бол шумуулд бид хэлчихье. Тэд нар бороонд ч хамаагүй нисч байгаад даливсан ойг самнаж, бэр олог.



Тэгтэл шумуулнууд хэлэв.

- Танай хүүд таарах бүсгүй манайханд бэлэн байж байна. Эндээс зуун алхамд, морин хадны бутан дээр залуухан эмгэн хумс орон гэртэйгээ байж байгаа. Нөхөрт гардаг нас нь ид болчхоод гав ганцаараа амьдарч байгаа юм. Эндээс хүний алхаагаар ердөө зуухан алхам.

- Манай хүү бүхэл бүтэн даливсан ойтой, тэр охин чинь уртаашаа ганц буттай юм байна. Өөрөө л манай хүү дээр ирэх нь лав гэж эцэг эмгэн хумс зарлиг болов.

Ингээд хүү эмгэн хумстай уулзахаар охин эмгэн хумс гэрээсээ гарчээ. Тэр даливсан ойд найм хоног явж байж хүрэв.

Язгуур угсаа нь хүртэл яг таарч, хоёул хуримаа хийлээ. Хурим найрынхныг зургаан гэрэлт цох хамаг чадлаараа гэрэлтүүлэн, хөгшид нь дуу чимээнд дургүйн улмаас чимээ шуугиан багатайхан шиг хуриглажээ.

Гэвч эх эмгэн хумс гайхамшигтай сайхан үг хэлснийг тэмдэглэвэл зохино. Харин сэтгэл нь нэн хүчтэй хөдөлсний улмаас эцэг эмгэн хумс үг хэлж хараахан чадсангүй. Үүний дараа хөгшид, бүх даливсан ойг залуустаа өмчлүүлэн өгч, тэд насан туршаа ярьж ирснээ одоо ч бас хэлж “Даливсан ойгоос нь сайхан газар орон орчлон хорвоо дээр ганц ч байхгүй” гээд, хэрвээ залуучууд та нар сайн сайхан амьдарч, үр хүүхэд төрүүлж гэмээ нь хожим өөрснөө үгүй ядахдаа, та нарын үр ач нараас ноёныхны хотонд хүрч, түлэгдэж харлатлаа чануулж, мөнгөн царан дээр тавиулах хувь заяа олох биз ээ” гэж ерөөв.

Эндээс хөгшид орон гэрээ зүглэж, дахиад хэзээ ч үзэгдсэнгүйг бодоход тэд үүрд нойрссон хэрэг биз ээ. Түүнээс хойш залуу эмгэн хумснууд ой төгөлдөө хаанчлан үй олон үр ач зээтэй болж өнөр өтгөн амьдарцгаах болжээ.

Харин өнөөх ноёны хотонд очиж мөнгөн царан дээр тавиулах нь бүтсэнгүй. Үүнээс болоод тэд ноёныхны өвөлжөө бууц хэдийнээ устаж алга болсон, хүмүүс нь ч ялгаагүй үхэж мөхжээ гэж бодоцгоов.

Энэ бол худлаа гэж тэднийг хэн ч эсэргүүцээгүй болохоор үнэхээр тийм юм болсон байж ч магадгүй ээ. Эмгэн хумснуудыг саатуулахаар ойд хур бороо шижигнэн орж, эдний халуун ам бүл жаргалтай сайхан байг гэж даливсын ой ногоорон ганхан гэрэлт наран мандсаар байлаа.

Эмгэн хумсын өнөр бүл ямар их аз жаргалтай байсан тухай яриа ийм бүлгээ.

Цэвэр мөнгөн зоос

Эрт урьдын цагт нэгэн зоос байлаа. Зоос цутгуураас дөнгөж саяхан гараад цэв цэвэрхэн, цав цайран гялалзаж "Алтан дэлхийгээр нэг аялан хэсэх минь боллоо. Юутай сайхан хэрэг билээ. Ура!" хэмээн баярлаж байж гэнэ.

Удалгүй аян замдаа гарчээ. Жаалхан жаалхан хүүхдүүд мөнгийг хөөрхөн дулаахан гартаа атгахаараа нэг атгаж, харамч харгис хүмүүс мөлүү оргисон гартаа сайтар базаж, хөгшин хөвөө хүмүүс алгандаа удтал бөмбөрүүлж, залуучууд алган дээрээ бахдалтайяа тавьж... энэ янзаар мөнгө маань цааш цаашаа явж гарчээ. Зоосонд орсон зэсний хольц маш бага, ихэнх нь мөнгө тул тэр хаагуур ч гэсэн саатах юмгүй аялан явжээ.



Өөрөөр хэлбэл, зоос үйлдвэрлэдэг газар бүхнээр явсан байна. Дараа нь нэгэнтээ эзэнтэйгээ цуг гадаад оронд очоод төрөлх орных нь мөнгөний хувьд гав ганцаараа хэтэвч дотор нь үлдчихэж гэнэ. Ингэлээ гэдгийг эзэн нь анзаарч мэдээгүй явсан ч нэгэнтээ түүнийг гаргаж хараад,

- Хөөе, яасан сонин юм гээч вэ? Манай орны нэг зоос надад яваа юм байна шүү дээ. Яахав, надтай баахан зугаацан аялбал аялаг гэсэн байна.

Ингээд эзэн нь түүнийг хэтэвчиндээ буцаан хийхэд зоос үлэмж их баярлан дэвхцэж жингэнэжээ. Зоос гадаадын баахан зоостой цуг эзнийхээ хэтэвчинд дээр, доороо орон явавч зарагдсан нь үгүй, байрандаа үлдэн хоцорсоор л байв.

Ийм янзаар олон долоо хоног өнгөрлөө. Эх орноосоо улам л холдоод байвч хаа хүрснээ үл мэджээ. Бусад зооснууд л "Энэ бол францууд,



эсвэл италиуд гэх юм уу, одоо бид ийм хотод байна, тийм хотод явна” гэхийг сонсовч өөрт нь мэдэж төсөөлөх юу ч үгүй, өөрөө ч бусдад харагдалгүй явсаар байлаа. Тэгснээ нэгэн удаа хэтэвч онгорхой байна гэдгийг мэдээд, ертөнцийг ганц удаа ч болсон хараад авахыг хүсэн бяцхан нүхээр гүйн гарч гэнэ.



Уг нь тэр ингэх хэрэггүй байсан ч туйлын сониуч зангаасаа болоод гарч одсон нь түүнд хожим багагүй зовлон авчирсан билээ.

Зоос гаруутаа нэг хүний өмдний халаасанд орчхов. Үдэш эзэн нь хэтэвчээ халааснаасаа гаргахад зоос өмдөнд нь үлдсэн ч өмдөө хонгилд аваачиж цэвэрлэхэд шалан дээр ойчив. Тэглээ гээд түүний газарт унахыг хэн ч үзсэнгүй, чимээгий нь ч сонсолгүй өнгөрчээ.

Өглөө нөгөө эзэн нь хувцаслаад гарч одоход зоос тэр газраа үлдэж гэнэ. Түүнийг шалан дээр хэвтээг удалгүй нэгэн хүн мэдэж зоос дахиад л ажилдаа орох болтол өөртэй нь адил хаягдаж хоцорсон гурван зоос байв.

“Ийм сайхан юм гэж байх уу? Дахиад газар дэлхийгээр хэрэн хэсч, шинэ шинэ хүмүүсийн нүүр царайг харна, шинэ шинэ ёс заншил үзнэ” гэж зоос баярлан бодов. Гэсэн ч тэрхэн хоромд “Энэ юун зоос вэ? Манай зоос биш л байна даа. Пөөх, хуурамч эд байна. Хаа ч үүний хэрэг байхгүй” гэлцэх нь сонсогдлоо.

Зоостой тохиолдсон явдал цаашид хэрхэн өрнөснийг тэр ингэж өгүүлсэн юм.

- Хуурамч эд байна! Үүний хэрэг хаа ч байхгүй гэхэд нь “Би бол цэвэр мөнгө! Жинхэнэ цэвэр цутгуурын зоос. Миний жингэнэх дуу ямар сайхан гэж бодно. Намайг зориуд гутааж байгаа юм. Намайг тэгж хэлнэ гэдэг бол муухай том алдаа юм шүү. Гэхдээ тэгж хэлээд л байгаа юм даа. Би хуурамч, очиж очиж хаа ч хэрэггүй эд байна гэнэ ээ” гэж түүнд бодогдсоор...

“За, гайгүй үүнийг би харанхуйгаар далимдуулаад үгүй

хийчихнэ ээ” гэж миний шинэ эзэн ярьж байснаа, нээрээ л хүнд өгчихсөн юм. Тэгээд дараа нь өдрийн гэрэлд хараад, дахиад л намайг хараан зүхэж эхэлдэг билээ. “Шал хуурамч зоос байна. Үүний хэрэг хаа ч байхгүй. Нэгэнд нь сэмхэн гулгуулчих юм сан” гэнэ.

Ийм учраас хэн нэгэн намайг тухайн орны зоосны оронд сэмээрхэн шургуулах гэх тоолонд би айж, ичиж үхэхээ дөхөж, дагжин чичирнэ.

- Еэ, чааваас. Би ямар заяа муутай зоос вэ... Миний мөнгөөр цутгагдсан нь, үнэт чанар минь, жинхэнэ цутгуурын аргаар гарсан минь бүгд ямар ч хэрэгцээгүй болдог нь юу вэ. Ер нь аливаа юм юуны төлөө заяагдсан бэ, тэр л янзаараа үлдэх ёстой биш үү. Муухай санаа, муу аргаар бусдыг мэхэлнэ гэдэг аймшигтай хэрэг учраас би өөрөө ямар ч буруугүй боловч буруутай мэт үзэгдэнэ гэдэг хэчнээн хэцүү гээч... Би л тэднийг ичгүүргүй залилах гэсэн мэт тэд намайг аваад л чулуудчихна гэдгийг мэддэг учраас би хэн нэгний гарт шинээр очих болгондоо үхтлээ айдаг билээ.

Нэг удаа хөөрхий ядуу бүсгүйн гарт очсон минь, тэр өдөржин хүнд хэцүү ажил хийснийхээ хөлсөнд намайг авснаас болсон юм. Дараа нь тэр намайг яаж ч аргалаад бусдад өгчхөж чадсангүй ээ. Учир нь намайг авах хүн олдохгүй, хөөрхий бүсгүйд би гай болчихоод байлаа.

“Аргагүйн эрхэнд бусдыг молигодохоос өөр аргагүй нь ээ. Би ийм ядуу байж ядахдаа хуурамч зоосыг хадгалаад яах ч билээ. Үүнийг талхны баян худалдаачинд өгч орхиё. Тэр энүүхнээс болоод хоосров л гэж. Гэхдээ л ингэнэ гэдэг чинь муухай юм аа. Маш муухай юм” гэж тэр хэлж байлаа.

- Би энэ хөөрхий эмэгтэйн сайхан сэтгэлийг хүртэл зовоож орхижээ. Ер нь миний санаа ийм муухай хувирчихсан юм биш биз дээ гээд би санаа алдсан юм даг.





Талхны баян эзэн үрүү эмэгтэй минь очсон ч мөнгөний чанарыг нэвтэрхий мэддэг худалдаачин түүнийг авсангүй. Шууд л хөөрхий бүсгүйн нүүр өөд буцаагаад чулуудсан юм. Намайг авч түүнд талхыг нь өгөөгүй тул надад гунигтай, би бусдыг гуниглуулж зовоохоор цутгагдсан юм гэхээс сэтгэлд минь маш хэцүү байлаа. Би хэзээ нэгэн цагт өөрийн хүч чадалд бүрнээ итгэдэг, зориг төгс, жингэнэсэн тодхон дуутай байж билээ. Одоо бол намайг хэн ч тоож авахгүй болохоор сэтгэлээр бүүр унаж гүйцэв. Гэвч эзэгтэй минь намайг гэртээ буцаан авчирч над уруу зелдгээр харж байснаа,

- Ер нь би хэнийг ч залилаагүй. Харин чиний хуурамч мөнгө гэдгийг чинь хүн бүр мэдэж байг гэж чамайг зүгээр л цоолчихъё. Тэгээд бас... Магадгүй чи бол бусдад аз жаргал өгдөг зоос байж ч мэднэ гэж бодогдоод байна. Зүйтэй, маш зүйтэй. Би чамайг нүхлээд утас сүвлэж хөрш айлынхаа охины хүзүүнээс зүүж өгье. Охин аз жаргалтай болно гэж хэлэв.

Ингээд тэр надад цоорхой гаргачхав. Цоорхой болно гэдэг миний хувьд тийм таатай зүйл биш боловч ариун сайхан зорилгын төлөө хэд ч хохирч болно шүү дээ. Нүхээр маань нарийн утас сүвлэхээр би ямар нэг медальтай төстэй болов.

Хөршийн охин намайг хүзүүндээ зүүгээд үнсэж, над уруу үе үе хараад, сав л хийвэл инээд алдаж, би хүүхдийн дулаахан ариухан элгэн дээр нэг шөнийг өнгөрөөв.

Өглөө нь охины ээж намайг авч үзсэнээ ямар нэг юм бодоод эхлэхээр нь би яах гэж буйг нь гадарлалаа. Тэр хайч авч, оосрыг нь минь тас хяргаад хаяв.

- Аз жаргалын зоос гэнэ ээ. Ямархуу зоос байна үзье л дээ гэж тэр эмэгтэй хэлж байна. Тэгсэнээ намайг хүчилд хийчихлээ. Би ногоон туяатай болон, нүх минь





яваандаа алга болчхов. Тэгснээ намайг авч жаахан өнгөлж байснаа оройн бүрий болмогц хонжворт сугалаа борлуулагч уруу азтай сугалаа авах юм болоод гарч өгөв өө. Надад энэ бүхэн яасан хэцүү байв аа. Намайг хавчуурт оруулаад тас огтлох гэж байгаа юм шиг л санагдсан юм. Би чинь өөрийн бичээстэй болоод үнэт чанараараа бахархан хэвтээ олон зоосны нүдэн дээр "хуурамч зоос" гэж шившиглэн гутаахыг нь үзэхээрээ нэг болсон шүү дээ.

Гэвч ашгүй нэг юм өнгөрлөө. Шившиглэлээс мултарч амжих нь тэр ээ. Мухлаг өчнөөн олон хүнтэй, худалдагч нь огтоос завгүй, намайг харах ч чөлөөгүй байсан тул шууд аваад бусад зоосон дунд чулуудаж орхидог юм байна. Надаар авсан сугалаагаар хожсон эсэхийг бүү мэд, харин нэг зүйлийг мэдэж байна. Тэр нь юу вэ гэвэл ердөө маргааш нь миний хуурамч болохыг мэдэж, өөр газарт тавьснаа бас л бусдыг хууран, зарахаар авч явж, дахин дахин бие биенээ мэхэлж гарсан юм.


Надаас үнэнч шударга зангий минь болиулж чадаагүй ч үнэхээр тэсэхүйеэ бэрх байсан даа. Тийм янзаар би бүтэн жил гаруй гараас гар дамжин, хаана л бол намайг харааж зүхэж газар бүхэнд уурлаж байв. Надад хэн ч итгэхгүй тэр байтугай, би олдсон биендээ ч орчлон хорвоод ч итгэж найдахаа болиод байсан юм. Гэвч энэ хүнд бэрх амьрал минь түр зуурынх байжээ.

Тэр удаа гадаадын нэг гийчинд намайг сарвайж гийчин маань яасан ч үгүй эндхийн мөнгөний оронд авлаа. Гэвч дараагийн удаа наймаа хийхдээ намайг өгөх гэтэл нь,

- Наадах чинь хуурамч юм. Гүйлгээнд тэнцэхгүй ээ гэхийг нь сонсов.

- Үүнийг жинхэнэ мөнгөний оронд надад өгсөн юм шүү дээ гэж гийчин эсрэг этгээддээ хэлснээ намайг гэнэт эргүүлэн тойруулан харлаа. Тэгснээ гэнэт түүний нүүрэн дээр инээмсэглэл тодрон, хэн ч намайг хараад инээж байгаагүйгээр инээж,





- Энэ чинь манай төрөлх эх орны лут сайхан зоос, жинхэнэ зоос байна. Зориуд цоолж нүх гаргачхаад хуурамч зоос гэлцээд байжээ. Юу гээчийн хөгийн явдал вэ. Үүнийг хаялгүй авч яваад эх орондоо очъё байз гэх нь тэр ээ.

Би ямар их баярлав даа, тэгэхэд. Намайг дахиад жинхэнэ мөнгө гэж байна.

Гэртээ аваад харина гэнэ. Хаа ч явсан хэн бүхэн намайг чанартай цутгасан цэвэр мөнгөн зоос гэж мэдэх болно. Би өөрөөсөө оч үсэртэл баярлав. Үгүй ээ, биш. Энэ нь миний шинж чанарт таарахгүй. Тэгвэл би мөнгө биш ган болчихно. Эзэн минь намайг хаях, бусад зоостой холилдохоос сэргийлэн жаахан цагаан цаасанд боож зөвхөн нутгийнхаа хүмүүстэй таарч уулзах үедээ л өврөөсөө баяртайгаар гарган, миний тухай ер бусын сайхан үг хэлдэг байв.

- Бүгд л намайг сонин байна, сайхан санагдаж байна гэнэ. Би ганц ч үг хэлэхгүй атал сонин байдаг нь бас ч хачин юм аа. Ингээд би орон улсдаа очлоо.

- Эдэлсэн зовлон минь төгсч аз жаргалтай боллоо. Намайг жинхэнэ цэвэр мөнгөөр бүтсэн, сайтар цутгагдсан, ямар ч гэмтэлгүй байхад нүхэлж хуурамч мэт болгосон юм. Хэрвээ таныг ч бас надтай адил ном ёсоороо нэгэн байхад чинь энэ мэтээр хуурамч, хуурамч гэсэн бол юутай их гамшиг вэ. Тэглээ ч гэсэн тэвчээр хатуужил чухал, цаг хугацаа өнгөрөхөд бүх юм хуучин байрандаа очдог юм шүү. Үүнд би бүр үнэнээсээ итгэдэг юм даа гээд зоос маань өөрийнхөө яриг өндөрлөлөө.



Эхийн дууль



Бяцхан үрээ үхчих вий гэхээс хязгааргүй их айж зовсон эх хүүхдийнхээ дэргэд сууж байлаа. Хүүхдийн нь царай улам бүр цайж, нүд нь аниатай, дөнгөж мэдэгдэхийн төдий амьсгалж, хормоос хоромд бие нь муудан өнгөрчих гээд байв. Хумсыхан үрээ харах бүр эхийн зүрх шимшрэн өвдөнө. Тэгтэл тэднийд гэнэт нэгэн гуйлгачин байрын өвгөн хаалгыг нь тогшин ороод ирлээ. Өвгөн яг л адуунд нөмөргөдөг нэмнээрхүү юм өмссөн ажээ. Энэ үес, дангинасан хүйтэн өвөл болж гадаа цул цас мөсөн хучлагатай, хүйтэн салхи нүүр хайрч байгаа болохоор дулаан нэмнээ хэрэгтэй байлгүй яхав.

Өвгөн даарснаасаа болоод чичирч, хүүхэд нь хоромхон зүүрмэглэх завсар эх зочиндоо аяга цай хийж, пийшин дээр халаахаар тавилаа. Өвгөн энэ үед өлгийтэй жаалд ойртон суугаад өлгийг нь хөдөлгөж байжээ. Эх хүүгийнхээ дэргэдэх сандал дээр суун хүндээр амьсгалахыг нь сонсон харж сууснаа гар дээрээ авав.

- Би охиноосоо хагацахгүй, тийм ээ. Бурхан үүнийг минь надаас юу гэж булаах билээ гэж эх өөртөө хэлж байв.

Харамсалтай нь тэр хөгшин бол Үхэл өөрөө байсан бөгөөд охины эхийн асуусан үгний хариуд нэг л хачин толгой дохих нь "тийм", "үгүй" гэсэн салаа утгатай байсан юм санжээ. Эх толгой унжуулан, хацрыг нь дагаад нулимс урсаж байв. Тэр янзаар маш их айж гунин гурван өдөр, гурван шөнө нүд хуурай байсангүй. Унтаж амарна гэдгийг эх хэдийнээ мартсан. Гэвч тэр удаа ганц хормын төдий зүүрмэглэснээ төдөлгүй даарч, давхийн сэржээ. Эх эргэн тойрноо харж,





- Юу болох нь энэ вэ хэмээн дуу алдав. Нөгөө өвгөн алга. Түүнтэй хамт хүүхэд нь бас алга. Өвгөн түүнийг нь аваад алга болжээ. Хөөрхий эх байшингаасаа гүйн гарч, хүүхдээ чанга дуугаар дуудав. Харвал урт хар хувцастай нэгэн эмэгтэй тэнд цасан дээр суугаад,

- Танайд Үхэл биеэрээ орсон юм шүү дээ. Тэр танай хүүхэдтэй нууцаар гараад явахыг би харсан. Үхэл салхинаас ч хурдан, нэгэнт авснаа тэр хэзээ ч өгдөггүй юм гэв.

- Тэр чухам аль замаар явав аа? Замыг нь надад заагаад өгөөч. Би олохдоо л олно гэж эх хэлэв.

- Тэр хаашаа явсныг би мэднэ. Гэхдээ чамд хэлж өгөхгүй. Чи хүүгийнхээ дэргэд сууж, хүүдээ зориулж дуулж өгсөн бүх дуугаа надад бүгдийг дуулж өгөхөөс нааш би зам зааж өгөхгүй. Би тэдгээр дуугийг чинь сонсохдоо маш их дуртай. Би бол Шөнө билээ. Чамайг хүүгийнхээ хажууд уйлан уйлан дуулж байхыг чинь олон удаа харсан юм гэж хар хувцаст бүсгүй хэлсэн байна.

- Би тэр бүх дуугаа нэгийг нь ч үлдээлгүй дуулъя аа. Гагцхүү намайг бүү саатуулж үзээрэй. Би Үхлийг гүйцэх, хүүгээ олж авах хэрэгтэй байна. Эх нулимсаа арчин арчин дуулж, Шөнө амьсгал даран чагнав. Эх өчнөөн төчнөөн удаа бүүвэйн дуугаа аялгуулан эгшиглүүлэн дуулж, тэр хэмжээгээр эхийн нулимс урсан урсан байлаа. Энэ бүхний эцэст Шөнө намуун дуугаар хэлэв:

- Баруун тийшээ бараалан байгаа их нарсан төглөөд яв. Үхэл тэр зүгт явчихна билээ.

Төглийн дунд олон замын уулзвар хүрээд эх зогслоо. Одоо хаачих билээ, энэ олон замын алинаар орох билээ? Замын уулзварын хажууд үүргэнийн нүцгэн бут харагдана. Үүргэнэ ганц ч навчгүй, цэцэг бүүр ч байхгүй, тачигнасан өвөл хойно арга ч үгүй биз. Ядахад түүний бараг бүх биеийг дангинатал мөс барин хөлджээ.



- Үүгээр Үхэл миний хүүхдийг аваад явж байхыг харав уу?

- Харах нь харсаан. Гэхдээ намайг элгэндээ наан зүрхнийхээ илчээр дулаацуулж өгөхөөс нааш тэр хаашаа явсныг би хэлэхгүй. Миний бүх бие мөстөн хөлдөж би үхдэг дээрээ тулаад байна.

Эх бутыг элгэндээ нааж өргөсөнд нь биеэ хатгуулан өргөс бүгдийн ормоор цус нь гооживч тэсэн тэвчиж, төдөлгүй хувхайрсан бут ногоорон цэцэглэв. Доромжлогдож ядарсан эхийн зүрхний илч дулаан тийм буюу. Үүргэнийн бут ч явах замыг нь зааж өглөө.



Зам явсаар эхийг нэгэн том нуурын дээр хүргэж өгсөн боловч нууранд хөлөг онгоц, хүний урманд ганц өнчин завь ч үгүй ажээ. Нуур нимгэхэн мөстэй тул түүнийг даах аргагүй байв. Ямар ч гэсэн эх нуурыг гатлах, хүүхдэдээ хайртай л бол цаана нь гарах хэрэгтэй байлаа. Гэвч эх гүнзгий нуурын усыг ууж шавхан цаана нь гарахаар шийдээд сөгдөн сууснаа шимж эхэлжээ. Энэ нь хүнзэс ахадсан зүйл боловч тэр эхийн хайр ид шидэд итгэж байв.

- Наад ажлаа орхи оо. Чингээд бүтэхгүй, үүнд орвол хоёулаа

ярьж тохирох юм байна гэж нуур хэлжээ. Би шүр цуглуулдаг билээ. Гэхдээ бүүр яг чиний нүдтэй адил тийм тунгалаг. Хүн хэзээ ч олж үзээгүй тийм гоёыг нь цуглуулдаг юм. Хэрвээ чи зөвшөөрвөл хоёр нүдээрээ уйлан надад өг. Би чамайг нөгөө эрэг дээрээ Үхэл өөрийнхөө цэцэгс моддыг үржүүлдэг асар том хүлэмжинд хүргэж өгье. Тэндхийн цэцэг, мод болгон нэг нэг хүний амь байдаг юм гэнэ лээ гэж тэр өгүүлэв.

- Би хүүхдээ л олж авч байвал надад өгөхгүй юм юу байх вэ?

Уйлж ханадаггүй эх урьд урьдаас улам ч их уйлан уйлсаар хоёр нүд нь нуурын ёроолд унаж тэрхэн дороо үнэт эрдэнийн хоёр шүр болон тогтов. Нуур эхийг шүүрэн аваад дүүжин дээр суулгасан мэт зөөлхөн мэлтгэнэсээр дорхноо нөгөө эрэгтээ гаргаж асар том, муухай гээчийн байшинд хүргэж өгч гэнэ.

Байшин нь уул өргөст бут ургасан, эв хавгүй агуй юм уу, үгүй бол барилга байшин ч юм уу ялгарахын аргагүй эд байжээ. Түүнийг хоёр нүднээсээ салсан эх яахин харж чадах билээ.

- Миний хүүхдийг хулгайлсан Үхлийг би хаанаас олох вэ гэж эх асуув.

- Тэр одоогоор эзгүй байгаа. Наашаа ирэх замыг чи яаж олов, хэн туслав чамд гэж үхлийн цэцэрлэгч хөгшин авгай асууж гэнэ.

- Ачит бурхан минь! Бурхан намайг өрөвдсөн юм аа. Та бас өрөвдөн нигүүлсэх биз. Хүүхдээ хаанаас олж болох сон бол хэлж өгөөч.

- Би мэдэхгүй байна. Ядаж чи нүдгүй юм. Урьд шөнө зөндөө олон цэцэг навч, ургаа мод унасан. Үхэл удахгүй ирээд тэднийг дахин суулгана. Хүн болгонд өөрт нь амьдралын мод, эсвэл цэцэг байдгийг, тэд цөм эзэнтэйгээ адилхан байдгийг чи мэднэ шүү дээ. Гаднаас нь харахад тэд цөм ерийн ургамал боловч бүгдээрэнд нь зүрх цохилж байдаг юм. Хүүхдийн зүрх ч ялгаагүй цохилж л байгаа. Тэгэхээр чи мод цэцэг болгоны дэргэд очиж чагна. Хүүхдийнхээ зүрхний лугшилтыг өөрөө таньж олно биз. Тэгэхдээ чи түүнээс цааш яахыг хэлж өгвөл надад юу өгөх юм бэ?

- Чамд өгөх юм одоо надад даанч байхгүй. Уг нь миний санаа

чамтай хамт ертөнцийн хязгаарт хүрсэн ч бэлэн л байна гэж энэлэлт эх өчжээ.

- Надад тэр хол явж эрэх юм байхгүй ээ. Түүний оронд надад өөрийнхөө харын хар, уртын урт энэ сайхан гээгээ өг. Би чамд буурал гээгээ өгье. Оргүйгээс эрхиш дээр. Чи түүнийг минь ав.

- Ердөө энэхэн үү? Би түүнийг баяртайгаар өгье. Ингээд эх харын хар гээгээ шодон буурал хэдэн үсээр нь сольжээ.

Дараа нь хүүхдийн ээж завсар зайгүй цэцэг навч, мод эгнүүлэн тарьсан асар том хүлэмжинд орж

явчихлаа. Шилэн халхавчин

доор уран гоёмсог хэлгий

цэцэг, далбагар далбагар

цээнэ гээд бусад цэцэг,

асар сүрлэг далдуу, царс

мод, яншуй, гоньдын

ургамал...хаа сайгүй

ургасан байлаа. Мод

цэцэг бүхний дэргэд

эзэн хүний нь нэр бичээстэй, мод цэцэг бүхэн нэг нэг хүний амь

юм санжээ. Энэ бүх мод цэцэгний эзэд ертөнцийн хаа сайгүй таран

одож Хятадад эсвэл Гренландын тэртээ хаа ч хэн нь ч явж байж

болох ажээ. Тэнд өчүүхэн вааранд тарьсан аварга том моддын

ваар нь задрах шахжээ. Хөв хагд бүрхсэн цэцгүүд зүйл зүйлээрээ

байх авч тэр бүгдийг машид нямбайлан арчилж тордож, хайрлаж

энхрийлэн байна.

Хөөрхий эх мод, цэцэг бүхнийг түүний дотор нүдэнд үл өртөм

өчүүхэн цэцэг бүхнийг ч очиж чагнасаар тэдгээр сая саяын дундаас

өөрийнхөө үрийн зүрхний цохилтыг андахгүй танив.

- Миний хүү энэ байна гэж толгойгоо унжуулан гунигласан

өчүүхэн зул цэцэг үрүү гараараа заан хэллээ. Тэгэхэд нь цэцэрлэгч

авгай:

- Цэцгэнд гараа бүү хүргэ. Үхэл эргэж ирэхийг би тэсч ядан

хүлээж байна. Наад цэцгийг чинь шилжүүлэн суулгах боломж

олгохгүйн тулд өөр ямар нэг цэцгийг суга татна гэж түүнийг



сүрдүүлээд үзээрэй. Бурханы санаа зоригоос гадуур ганц ч цэцгийг сугалж болдоггүй учир цаадах чинь айх болно гэж цэцэрлэгч авгай хэлэв. Тэгтэл мөсөн хүйтэн жавар сэнгэнэн Үхэл ирж байгааг нүдгүй болсон эх мэдлээ.

- Чи яаж зам олов? Тэгээд бас надаас түрүүлээд ирж яаж чадав аа гэж Үхэл асуув.

- Би Эх учраас гэж хүүхдийн ээж хариулжээ.

Тэгтэл Үхэл ёрдгор гараа хөөрхий бяцхан цэцэг үрүү сунгасанд ганц ч дэлбээгий нь сэвтээлгэхгүйн тулд эх гараараа яаран халхлав. Тэгэхлээр нь Үхэл эхийн гараад үлээгээд орхисонд умрын салхинаас ч хүйтэн амьсгалаас болоод эхийн гар мэдрэлгүй сул унжжээ.

- Чи надтай мөчөөрхөөд нэмэргүй гэж Үхэл хэллээ.

- Гэвч бурхан чамаас хүчтэй шүү гэж Эх хариулав.

- Би бол зөвхөн бурханы тушаалыг биелүүлэгч. Би түүний цэцэрлэгчийн хувьд цэцэгс, моддыг хүлээн авч нөгөө тивд аугаа их диваажингийн цэцэрлэгт тариалдаг билээ. Миний тарьсан цэцэгс, модод тэнд хэрхэн ургадаг гэдгийг би чамд хэлэх эрх алга гэж эхэд Үхэл хэлэв гэнэ.

Тэгэхэд нь нулимсандаа нэвчсэн эх,

- Алив миний хүүхдийг өгөөтөх гэж Үхэлд хэлснээ дэргэдээ байсан асар том хоёр цэцэгнээс шүүрэн бариад,

- Би чиний бүх цэцгийг бүгдийг тасдан хаяна. Би нэгэнт дүүрсэн хүн, яахаас ч буцахгүй шүү гэж хашгирсан байна.

- Цэцэгнүүдийг минь бүү хөнд. Чи өөрөө зовж байна гэх, тэгсэн мөртлөө өөр нэгэн эхэд зовлон тарьж яах нь вэ гэж Үхэл өгүүлэв.

- Өөр нэгэн эхэд гэнэ ээ хэмээн эх цэцэгнүүдээс гараа авлаа.

- Май энэ чиний хоёр нүд. Би эднийг чинь нуураас авахад ямар гоёор гялалзаж байсан гэж бодно. Харин чиний нүд гэдгийг мэдээгүй билээ. Эднийг одоо ав. Нүд чинь урьдаасаа ч тунгалаг болсон. Одоо энэ гүнзгий худаг уруу өнгийж хараад үз. Би чиний



тасдах гээд байсан цэцэгнүүдийг нэрээр нь дуудамз. Чи тэдний ирээдүйн амьдрал, газар дэлхий дээр туулсан замыг нь тэнд бүгдийг нэгд нэгэнгүй харах болно. Чи чухам юу юуг устгах гээд байснаа одоо хар гэж Үхэл хэлэв.

Тийнхүү хүүхдийн эх өмнөх худаг уруу хартал амьдрал гайхамшигтай сайхан, хүний нэгэн амьдрал өөртөө төдийгүй эргэн тойрныхондоо ямар сайн сайхан юмс бэлэглэн байгаа нь бахдаж ханашгүй байв. Бас өөр нэгний базаахгүй, гунигтай, ядуу дорой, цөхөрсөн амьдрал ч худагт харагдав гэнэ.

- Хоёулаа л бурханы эрх зоригоос болж байгаа юм аа хэмээн Үхэл нэмж өгүүлэв.

- Аль цэцэгнийх нь амьдрал зовлон, алиных нь жаргал байгаа юм бэ гэж эх бас шалгаав.

- Үүнийг би хэлэхгүй ээ. Гэвч тэдгээрийн нэгнийхэд өөрийнхөө төрсөн охины амьдрал түүний бүхий л ирээдүйг харсан гэдгээ л мэдвэл барав гэж Үхэл түүнд хариулав. Үүнийг сонсоод эх цочих мэт дуун алдлаа.

- Миний үрийг ямар хувь заяа хүлээж байгаа бол? Надад хэлээч дээ. Гэмгүй үрийг минь өршөөн хайрлаач. Тэр бүх зовлон гай гамшгаас охиныг минь авраач. Ер нь охиныг минь авдгаараа авсан нь дээр юм байна. Тэрнийг минь бурханы мэдэлд авдгаараа ав. Миний залбирал, гуйлт, нулимс, миний ярьсан бүгдийг одоохон март!

- Би бүүр ойлгохоо байлаа. Намайг охиныг чинь буцаан өг гээд байгаа юм уу. Эсвэл нөгөө тивд аваач гээд байгаа юм уу гэж Үхэл дуугарав. Эх өвдөг дээрээ сөгдөн унаж залбиран хэлсэн нь,

- Чиний хүсэл зоригоос гадуур миний хүсч гуйсан юуг ч битгий тоо. Намайг битгий хэрэгс. Эх ийнхүү өгүүлээд толгой гудайн зогсчээ.

Үхэл хүүхдийг нь диваажин уруу аван одсон гэнэм.



Буурцган дээр хоносон гүнж

Эрт урьд нэгэн хунтайж байж гэнэ ээ. Хунтайж гүнжтэй болохыг, тэгэх тэгэхдээ хамгаас ухаантай жинхэнэ гүнж авах сан гэж хүсчээ. Энэ хэргээр хунтайж хамаг дэлхийгээр хэрэн хэсч эрсэн боловч харамсалтай нь хамгаас ухаантай жинхэнэ гүнж олдож өгдөггүй ээ. Хань болохоор гүнж хаа сайгүй байлаа ч жинхэнэ цэцэн ухаалаг нь мөн үү, биш үү танигдаж өгөхгүй байлаа. Нэгэнт тийм сайн гүнжээ олоогүй болохоор гайхаж гуньсаар гар хоосон гэртээ буцавч жинхэнэ сайн гүнжийг олох юм хуна даа гэж жигтэйхэн их хүсч байв.

Тэгтэл нэгэн үдэш агаар тэнгэр муухайрч, аянга цахилгаан гялалзан, тэнгэр дуугарч бороо хувин хувингаар ус цутгаж байгаа юм шиг орж аюул болох нь тэр гэнэ ээ.

Тэгтэл энэ үеэр хотын хаалгыг хэн нэгэн балбах нь сонстож хөгшин хаан хаалгаа онгойлгож өгөхөөр явав. Харахнаа хаалган дээр нь нэгэн гүнж ирчхээд зогсож байх нь тэр. Бурхан минь, тэр хэнтэй ч зүйрлэх аргагүй ямар сайхан гүнж гэж санана аа. Гүнжийн үс гээг, өмссөн хувцаснаас савирсан ус оймс, шаахай дээр нь урсан тэвдүүхэн харагдаж байсан ч хэлж баршгүй сайхан гүнж гэдэг нь хэнд ч гэсэн мэдэгдэж байлаа.

“Олигтойхон гүнж мөн үү, биш үү. Одоохон бид мэдээдэхье” гэж ноёны хөгшин хатан бодсоноо ганц ч үг ганхийлгүй унтлагын өрөө үрүүгээ ороод явчхаж гэнэ.

Хатан тэр дороо хамаг орныхоо гудаснуудыг хамж аваад ширхэг буурцагны үрэн дээр хорин ширхэг гудас давхарлан дэвсэж, дээр нь бас хорин өдөн дэвсгэр мөн л давхарлаж дэвсэж





гэнэ. Энэ их дэвсгэр дээр гүнж тэр шөнө нойрсож амрахаар хэвтжээ. Хэр сайхан нойрссоныг нь хэрэг болгон өглөө нь асууцгаажээ.

- Ээ, та минь ёстой муу унтлаа. Нүдээ ганц ч хамхисангүй. Надад ямар гээчийн ор дэр засч өгснийг бурхан л мэдэх байх даа. Би юу ч юм нэг айхтар хатуу юман дээр хэвтэж хоносон учир хамаг бие минь хөх няц болж гүйцлээ. Жинхэнэ зовлон гэдэг л энэ байх гэж гүнжтэн хэлжээ.

Үүнийг нь сонсоод, "Ёстой жинхэнэ гүнж байна, гарцаагүй гүнж мөн байна" гэж хүмүүс үзлээ. Гудас, өдөн дэвсгэр нийлсэн дөчин давхар дэвсгэр доорх ширхэг буурцгийг ингэж андахгүй сайн мэднэ гэдэг бол гагцхүү жинхэнэ цэцэн гүнжийн гаргуун ухааны тэмдэг билээ.

Ингээд хунтайж маань гүнжтэй болов. Одоо л нэг гарцаагүй сайн гүнжтэй боллоо гэж бахархан боддог болжээ. Мэдээж дурсгалт буурцгаа үнэт ховор зүйл хадгалдаг музейд тавьж хадгалуулсан юм гэнэ лээ. Хулгай зэлгий л авчихгүй бол буурцаг хаачих вэ, байж л байгаа биз.

Энэ бол түүхэнд болсон сониноос сонин явдал.



Хааны шинэ хувцсыг бүх дэлхий өмсөж байна

Ханс Христиан Андерсеныг хорвоогийн бүх хүүхэд мэдэх болжээ. Уг нь тэр хүүхдэд зориулан бичиж байна гэж боддог байсан ч гайхамшигтай зохиолууд нь бяцхан уншигчдаас хальж, томчууд ч түүний зохиолд автжээ.

Их Андерсен мэндэлсээр эдүгээ 201 дэх жилтэйгээ золгож байна. "Нугасны муухай дэгдээхий"-г уншаагүй, үгүйдээ л сонсоогүй хүн ховор биз. "Хааны шинэ хувцас"-ыг ч бас ялгаагүй.

Андерсены зохиолууд өргөн олон уншигчдад яагаад тийм үнэмшилтэй, сонирхолтой байдаг вэ гэсэн асуулт гарна. Учир нь "Муухай дэгдээхий"-рхүү хүн амьдралд бишгүй дээ байдаг. "Нүцгэн хаан" ертөнцөд бас олон аж. Энэ хаанархуу хүн өдий төдийгөөрөө байж эрх ямба, нэр төр, эд агуурсад үхэн хатан дурлаж, ухаантай хүний дүр эсгэж, өөрсдийн гэм дутагдлыг илэрчхээс айн тэвдэж байдгийг Андерсены "Хааны шинэ хувцас"-т гарсан шиг үнэн агаад хөгжилтэй дүрсэлсэн зохиолч олон байхгүй.

"Эрэлхэг тугалган цэрэг"-ийн тухай бодъё л доо. Эцсийн эцэст тэр юунд гал дунд орж үхдэг вэ? Хааны цэргүүд гудамж дүүрэн бүрээ, бөмбөрөө нижигнүүлэн жагсаж, догшин ширүүнээр алхан явахад өвгөн гуталчин хамаг чадлаараа алхаа нүдээд бүрээ бөмбөрийн яршигтай дууг дарж чадахгүйдээ цөхөрч, цэргийн олон зуун хүний гутал зассан гуталчин сүүлд нь өөрөө гуталгүй болж хөл нүцгэрдэг билээ. Хааны цэрэгт алба хааж явсан тэрбээр нас барахын цагт улсын далбаагаар бүтээлгэн мөнхөд нойрсох ёстой байтал эхнэрийнхээ алчуур төдийгөөр хучуулан ертөнцөөс одож байдаг.

"Алтан гургалдай", "Яргуй", "Цасан хатагтай", "Хүүхэлдэйн театрын дарга", "Сүүдэр", "Дусал ус" зэрэг зохиол болгонд нь

амьдралын гуниг харамслыг мэдэрч харуусал зовнил, инээд наргиа, хошин өгөө энэ бүхнээр дамжуулан уншигч олны сэтгэлийг баясуулсан, үнэнийг нээсэн ухаарал, хүч чадал бүгд бий.

Эл зохиолч ингэж зохиол, үлгэрүүдээ бүх хүн төрөлхтөнд халуун сэтгэлээсээ бэлэглэсэн юм. Харин энэ хайрын хариуд хүмүүс түүнийг амьд сэрүүнд нь тийм ч их хайрлаж чадаагүй ажээ.

Андерсен ядмаг зүдмэг, түүний очсон газар суут үлгэрчийг олноор бядан явж амь зуудаг хэрмэл жүжигчидтэй олонтаа андуурч байжээ. Тэр хүмүүсийн дунд байхыг нэн их хүсдэг байв. Андерсен маш их аялан жуулчилж Европ, тэр байтугай Дорнын зарим оронд очиж үзсэн нь түүний дээрх хүсэлтэй холбоотой биз ээ.

Зохиолоо харин чимээгүй буйд газар бичдэг, олон сайхан үлгэрийнх нь анхны "сонсогчид" нь хэрэм, тодол шувуу, хээрийн салхинд найгасан хуш, хус, нарс, хөх тэнгэр байсан гэж Оросын алдарт зохиолч Константин Паустовский суут зохиолчдын тухай номондоо дурджээ.

Олны хайртай зохиолч мөнгө, эд юмсаар байнга дутаж гуцаж явжээ. Тэр байтугай гэрээс гарч явж чадахгүй, өмсөх пальтогүй болчихсон үе ч байжээ. Өөр хүн сэн бол энэ байдалд машид гутран яах байсныг бүү мэд. Тэгэхэд Андерсен:

- Би урьд нь нүцгэн хааны тухай үлгэр бичээгүй бил үү. Тэгсэн одоо өөрөө хувцасгүй болчхоод байх юм даа хэмээн инээж наадаж байжээ.

Үнэндээ гэвэл тэр инээдний цаана алтны үнэтэй үлгэрүүдээ харамгүй бэлэглэсээр атал хүмүүс, энэ орчлон өөрт нь хэрхэн хандаж байгааг мэдрэхдээ гуньсан гуниг, хүмүүсийг даажигнасан хариу тохуурхал байсан ч байж магадгүй.

Андерсен ямар ядуу байдалд орж, гэртээ бүгэх болсныг сонссон саваагүй хүмүүс цонхоор нь харж шоолцгоож байсан гэдэг. Андерсеныг нас барахад түрийвчинд нь цорын ганц нэгтийн доллар үлдсэн тухай яриа байдаг юм. Гэхдээ тэр ганц доллар зохиолчийн хувьд ямар их үнэтэй эд байсан гэж санана.

Өвлийн нэг хүйтэн өдөр зохиолч маш нимгэн хувцастай

гудамжинд олны өмнө үлгэрээ уншжээ. Их хүйтэн байсан болохоор зохиолч маань чичрэн дагжиж байхыг харсан нэгэн хүүхэд,

- Бидний хайртай Андерсен хувцасгүй юм байна шүү дээ гэж хашгирчээ.

Тэр өдрийн орой шуудан зөөгч зохиолчийн хаалгыг зөөлхнөө тогшин орж ирж мөнөөх өдрийн хашгирдаг жаалхүүгийн буй хөрөнгө болох ганц долларыг авчирч өгсөн байна. Түүнийг нь Андерсен ямагт өвөртөө нандигнан авч явдаг байсан тухай номоос уншлаа.

Тэгэхлээр тэр долларыг хэрэг дээрээ доллар биш сая сая хүүхдийн их зохиолч өөрийн нь хайр, гайхамшигт үлгэрүүдийн хариуд ирсэн гол шагнал гэж үздэг байсан ч юм билүү. Андерсены олон үлгэрийг Монголын уншигчид мэднэ. Харин тэр үлгэрийнхээ хажуугаар шүлэг бичиж явсныг нь зарим хүн мэдэхгүй байж болох юм.

Д.Цоодол

Сагстай өндөг

Улсын хөлтэй хотоос холгүй нэгэн толгойд
Уртаашаа ганц тахиатай тариачин бүсгүй байв.
Эм тахиа гэдэг эм тахиа л хойно доо
Эзэндээ өдрийн л нэг өндөг гаргаж өгдөг гэнэ.
Мань хүүхэн нэг өдөр дотроо банжсан чинь
Маргаан байхгүй өндөгнүүд нь хорь, гуч болж гэнэ.
Торон сагсанд тэднээ нямбай гэгч нь хийж
Толгой дээрээ тавиад хот орохоор явж гэнэ.
Хүрэх газар хол, ганцаар явахад уйтгартай
Хүүхэнд элдвийг бодох зав энд л нэг гарчээ.
Хүн болгон цагаа болоход ижилхэн
Олз хөрөнгийн ихийг цөмөөрөө л хүсдэг хойно
Олигтойхон олъё, долъё гэж тэр ч бас бодож гэнэ.
Хорь, гучин зоосоо зөндөө болгоё
Холын замдаа бүсгүй улам их яарч гэнэ.
Тэнд очоод мөнгөжмөгц хоёр тахиа авъя
Тэгээд гурван тахиатай, бүгдээс нь өндөг авъя
Гурван тахиа гэдэг, мөнгийг тарьж болно
Гуниггүй аятайхан би ч догь амьдарна
Үй олон өндөгнөөс хагасыг нь зарна.
Үлдсэн нь яахав ангаахай дэгдээхий болно.
Үймж шуугиад манай хашаагаар нэл тахиа
Будилуухан эзэн нь өндөг, тахиан дундаа төөрчихмөөр

Бурханы минь аврал, ингээд баяжих нь тэр дээ.
Эхлээд хэдэн галуу, дараа нь баахан хонь
Энгээ тэлж өндөг тахиа, өд, ноосоор будилна даа!
Сайн гахайн тоорой мэдээж бас авна.
Саалийн үнээ, тэгэхдээ бүр хоёрыг авна аа.
Ганц жил өнгөрөв гэхэд л шинэ ордон босгоно
Газар газраас эр, эмгүй надад бараалхах гэж цувна
Гадаа налайтал сүргээ тууж ирээд хотлуулна
Ханхар сайхан харшийн дэргэд залуу эр
Хайртай боллоо, гараа надад өгөөч
Ханилж суухыг гуйя гэж хүснэ.
Харах ч үгүй би бардам гэгч нь өнгөрөөнө...

Хамаг өндөг нь унаж хага үсэрлээ
Харш сайхан орд нь ч дорхноо будаа боллоо...
Халаглаад одоо яахав, дажгүй биз дээ.

Булал Окүджова (ОХУ)

Бяцхан цаасан цэрэг

Цэх халуун зоригтой, царайлаг хөөрхөн
Цэрэг эр энэ хорвоод байжээ.
Гэм нь харин тэр хөөрхөн цэрэг
Гэнэхэн жаалуудын тоглодог цаасан цэрэг юм санжээ.
Өөрөө тэр утсан дээр тохоостой
Өчүүхэн цаасан цэрэг гэлээ ч
Дээрх хүмүүс нь бүгдээрээ жаргадаг
Дэлхийг бүтээх сэн гэж тэр хүсдэг юм байжээ.
Өрөөлийн төлөө гал, усанд
Өчнөөн удаа орохоос ч айхгүй түүнийг
Ядмаг муу цаасан цэрэг
Яаж чаддаг юм бэ гэж хүмүүс шоолцгоолоо.
Ярих, ярихгүй юмаа түүнд итгэж хэлээд хэрэггүй
Яагаад гэвэл тэр цаасан юм чинь гэж голцгоолоо.
Гал уруу өрсөөд намайг орчихвол яахав гэхэд нь
Гайхах юу байхав, үсрээч! гэж тохуурхацгаалаа.
Цаасан цэрэг тэгтэл гал уруу ороод явчхаж
Цаана нь юу ч үлдэлгүй үнс болоод дуусчээ.
Цагтаа тэр үнэхээр цаасан цэрэг байсан юм чинь дээ.

Гарчиг

Хэн нь хурдан бэ?	3
Дэглий шувуудын тухай үлгэр	7
Гахай- мөнгө хураагуур.	14
Чин үнэн явдал	18
Жаргалтай ам бүл	22
Цэвэр мөнгөн зоос	27
Эхийн дууль.	33
Буурцган дээр хоносон гүнж.	40
Хааны шинэ хувцсыг бүх дэлхий өмсөж байна	42
Сагстай өндөг	45
Бяцхан цаасан цэрэг.	47



Дэлхийн банктай хамтран хэрэгжүүлж буй
«Хөдөөгийн боловсролыг дэмжих
(READ) төсөл»-ийн хүрээнд хэвлэв.
Худалдахыг хориглоно.